



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРТ ХАМРАГДАЖ БУЙ
ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД
МОНГОЛ УЛС БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Улаанбаатар хот
2023 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРТ ХАМРАГДАЖ БУЙ
ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД
МОНГОЛ УЛС БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Улаанбаатар хот
2023 он

ННА 65
ДАА 330
Х-655

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн судалгааны баг

© Нээлттэй Нийгэм Форум, 2024 он
Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207

Факс: 976-11-324857

Веб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ISBN: 978-9919-9083-2-4

АГУУЛГА

ХУРААНГУЙ	8
I. УДИРТГАЛ	9
II. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРЧМУУД	12
УЛС ОРНУУДЫН САЙН ТУРШЛАГА	14
III. НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА	19
3.1 Монгол Улсын татварын орчин	19
3.1.1 Татварын үндсэн үүрэг, тэдгээрийн Монгол Улс дахь хэрэгжилт	20
3.2 Монгол Улсын ХХОАТ-ын тогтолцоо	23
3.2.1 ХХОАТ ногдуулж буй орлогын эх үүсвэрийн танилцуулга, бусад улс оронтой харьцуулсан байдал	23
3.2.2 ХХОАТ-ын орчин дахь шинэчлэл, өөрчлөлтүүд, тэдгээрийн үр дүн	26
3.2.3 Монгол Улсад хэрэгжиж буй ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт	28
3.2.4 Монгол Улсын ХХОАТ-т нөлөөлөх хүчин зүйлс	31
IV. МОНГОЛ УЛСАД ХХОАТ НОГДУУЛЖ БУЙ ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ	33
4.1 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын танилцуулга, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд	33
4.2 Үйл ажиллагааны орлогын танилцуулга, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд	37
4.3 Хөрөнгийн орлогын танилцуулга, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд	42
4.4 Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын татварын зохицуулалт, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд	44
4.5 Шууд бус орлого, түүний үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд	48
4.6 Бусад орлогын татварын зохицуулалт, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд	50
4.7 Оршин суугч бус албан татвар төлөгч	52

V. ХХОАТ-ЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД	54
5.1 Албан татвар төлөх ёстой иргэд шударга байдлаар ХХОАТ төлөх зарчим зөрчигдсөн	54
5.2 ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт иргэдийн санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзаж үзээгүй.....	58
5.3 ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн ангилал хэт ерөнхий, тодорхой бус.....	59
5.4 ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн хувьд хэрхэн тайлагнах, төлөх, тооцоолох нь хялбар, ойлгомжтой биш.....	60
VI. ХХОАТ-ЫН БОДЛОГОД ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖИТ ХУВИЛБАР.....	61
6.1 Олон улсын туршлагаас суралцах нь.....	61
6.1.1 Албан татварын шударга байх зарчмыг хангах.....	64
6.1.2. ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөд иргэдийн санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзан үзэх	65
6.1.3 ХХОАТ ногдох орлогын эх үүсвэрийн ангиллыг тодорхой болгох.....	66
6.1.4 ХХОАТ тооцоолох, тайлагнах, төлөх үйл явцыг хялбар, ойлгомжтой болгох	67
6.2 ХХОАТ-ын бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарууд.....	68
ДҮГНЭЛТ	71
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	74
ХАВСРАЛТ	76
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	79

ТОВЬЁГ

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 1.	ХХОАТ-ыг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлт.....	18
Хүснэгт 2.	Хувь хүний орлогын албан татвар ногдуулж буй орлогын эх үүсвэрүүд, улс орнуудаар	25
Хүснэгт 3.	ХХОАТ-ын тухай хуульд сүүлийн 30 жилийн дотор орсон шинэчлэлт, өөрчлөлтүүд	26
Хүснэгт 4.	2022 оны ХХОАТ-ын тухай хуулийн шинэчлэл, цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогод ногдох албан татварын шатлал.....	28
Хүснэгт 5.	ХХОАТ-аас хөнгөлөлт эдэлсэн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2020 он	30
Хүснэгт 6.	ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2020 он	31
Хүснэгт 7.	Монгол Улсын ХХОАТ-т нөлөөлөх онцлог шинж чанар, хүчин зүйлсийн нэгтгэл.....	31
Хүснэгт 8.	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл.....	33
Хүснэгт 9.	Монгол Улсын ХХОАТ-ын тухай хуульд заасан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод үзүүлэх хөнгөлөлт.....	35
Хүснэгт 10.	Үйл ажиллагааны орлого, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл.....	37
Хүснэгт 11.	Хөрөнгийн орлого, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл	42
Хүснэгт 12.	Хөрөнгийн борлуулсан, шилжүүлсний орлогод ногдох татварын зохицуулалт	45
Хүснэгт 13.	2022 оны эхний хагас жилд хийгдсэн үл хөдлөх эд хөрөнгө болон газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэлийн тоо хэмжээ, гэрээ хэлцлийн төрлөөр	47
Хүснэгт 14.	Шууд бус орлогын татварын зохицуулалт	48
Хүснэгт 15.	Бусад орлогын татварын зохицуулалт	50
Хүснэгт 16.	Оршин суугч бус албан татвар төлөгчийн тодорхойлолт.....	53
Хүснэгт 17.	ХХОАТ-т тулгарч буй асуудлууд, тэдгээрийн үүсэж буй шалтгаан болон үүсэх сөрөг үр дагавар.....	54

ЗУРГАН МЭДЭЭЛЭЛ

Зураг 1.	ХХОАТ-ын тухай хуульд тусгагдсан албан татвар ногдох орлого	24
----------	-------------------------------------------------------------------	----

ГРАФИК МЭДЭЭЛЭЛ

График 1.	ДНБ-д татварын эзлэх хувь хэмжээ, улс орнуудаар, 2021 он	19
График 2.	Монгол Улсын татварын орлого, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2020 он	20
График 3.	Монгол Улсын төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэл, 2020-2022 он	20
График 4.	Төсвийн орлогын бүтэц, бүс нутгуудаар, 2022 он	21
График 5.	Монгол Улсын төсвийн зардлын бүтэц, 2021 ба 2022 он (нийт зардалд эзлэх хувиар)	22
График 6.	Монгол Улсын Жини индекс	22
График 7.	Монгол Улсын ХХОАТ ногдуулах эх үүсвэрүүд, эзлэх хувиар (2018-2022 он)	26
График 8.	ХХОАТ-ын дүнд эзлэх цалин, түүнтэй адилтгах орлого (2019-2023 он)	34
График 9.	ХХОАТ-ын дүнд эзлэх үйл ажиллагааны орлого (2019-2023 он)	39
График 10.	ХХОАТ-ын дүнд эзлэх хөрөнгийн орлого (2019-2023 он)	43
График 11.	Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулсан албан татварын хэмжээ, ХХОАТ-т эзлэх хувиар, 2016-2023 он	46
График 12.	Шүүд бус орлогод ногдуулсан албан татварын хэмжээ, ХХОАТ-т эзлэх хувиар, 2016-2023 он	50
График 13.	Бусад орлогод ногдох албан татварын хэмжээ, ХХОАТ-т эзлэх хувиар, 2016-2023 он	52
График 14.	Монгол Улсын авлигын индекс, 2004-2022 он	57

ХАВСРАЛТ

Хавсралт 1.	Сингапур Улсын татвар ногдох орлогын эх үүсвэрүүд	76
Хавсралт 2.	Сингапур Улсын ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт	77
Хавсралт 3.	Ирланд Улсын ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт	78

ТОВЧИЛСОН ҮГС

OECD	Organization for Economic Co-operation and Development (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага)
ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
МТА	Монголын татварын алба
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУВС	Олон улсын валютын сан
ОХБОХ	Орлогын хяналт буцаан олголтын хэлтэс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТЕГ	Татварын ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман Улс
ХК	Хувьцаат компани
ХХАГ	Худалдах, худалдан авах гэрээ
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦХХ	Цалин хөлс хөдөлмөр

ХУРААНГУЙ

Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварт ногдуулах (1) цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, (2) үйл ажиллагааны орлого, (3) хөрөнгийн орлого, (4) хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, (5) шууд бус орлого, (6) бусад орлого гэсэн 6 үндсэн эх үүсвэрийг тусгасан байдаг.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын ХХОАТ-ын тухай хууль болон холбогдох нээлттэй мэдээ мэдээллийг ашиглан Монгол Улсын ХХОАТ-т хамрагдаж буй орлогын эх үүсвэрүүд, тэдгээрийг хэрхэн ногдуулж буй, татварын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлт зэргийн өнөөгийн нөхцөл байдлыг судалж, Казахстан, Сингапур, Ирланд Улсын ХХОАТ-ын тогтолцооноос суралцах боломжит кейс судалгаа болон баримтын шинжилгээг хийв.

Судалгааны үр дүнд Монгол Улсын ХХОАТ-ын ачаалал нь татварыг суутган төлөх тогтолцоогоор хэрэгжиж буй, хэрэгжилт өндөр орлогын эх үүсвэрүүдэд илүү их төвлөрч, харин татвар төлөгч өөрөө тайлагнах орлогын эх үүсвэрүүдийн хэрэгжилт сул байгаа нь харагдлаа. Үүнд үндсэн хоёр шалтгаан байна. Тухайлбал: (1) Татвар төлөгчид ХХОАТ-ын тухай хуулийн талаар мэдлэг дутмаг, мөн татварт хандах сөрөг хандлага өндөр, (2) Татварын тухай хууль хэт өргөн цар хүрээг агуулсан, орлогын эх үүсвэр бүрийн үрсгалыг хянаж чадахгүй байдлаас үүдэн татвар төлөгчид орлогоо ямар ангилалд оруулан тайлагнах талаар эргэлзээ үүсдэг, эсвэл албаар нуун дарагдуулах үндэслэл нь болж байна. Хэдийгээр орлогын эх үүсвэрүүдийг үндсэн том бүлэгт хуваан авч үзэх нь ирээдүйд шинээр бий болж буй орлогын эх үүсвэрүүдийг хамруулахад хялбар болох хэдий ч тэдгээрийг нарийвчлан ямар ангилалд байх ёстой тухай заавар байхгүй нь татвар төлөгчдөд өөрсдөө тайлагнан төлөх үйл явцад хүндрэл учруулж байна.

Мөн судалгааны хүрээнд ХХОАТ-ын хэрэгжилт болон үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр судлаачдын зүгээс санал, зөвлөмж дэвшүүлээ.

I. УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь төсвийн орлогын нэг чухал эх үүсвэр бөгөөд төрийн үйлчилгээ, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай санхүүжилтийг бий болгох, мөн орлогын тэгш байдал, ажиллах хүчний оролцоо, цаашлаад эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангахад нөлөөлж байдаг. Иймд юуны өмнө одоогийн Монгол Улсын ХХОАТ-т хамрагдаж буй эх үүсвэрүүдийг шинжлэн судалж, олон улсын туршлагатай харьцуулах замаар хэрхэн илүү үр ашигтай болгох чиглэлээр бодлогын санал, санаачилга дэвшүүлж байх нь чухал юм.

Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварт ногдуулах дараах 6 үндсэн эх үүсвэрийг тусгасан байдаг. Үүнд: (1) цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, (2) үйл ажиллагааны орлого, (3) хөрөнгийн орлого, (4) хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, (5) шууд бус орлого, (6) бусад орлого. Эдгээрийг олон улстай харьцуулан харвал ангилал, татвар ногдуулах зарчим болон хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зохицуулалт нь хэт ерөнхий, эдийн засаг, нийгмийн бодлогын оновчтой хэрэгсэл болж чаддаггүй байх магадлалтай байна. Энэ нь зарим тохиолдолд татвараас зайлсхийх арга хэрэгсэл болох эрсдэлтэй юм.

Иймд орлогын боломжит бүх эх үүсвэрийг ХХОАТ-т хамруулах нь эрх тэгш байдлыг бий болгон, татвараас зайлсхийхээс сэргийлэх, татварын хэрэгжилтийг дэмжиж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх ба улмаар Засгийн газрын орлогыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой. Энэ нь эргээд төрийн үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил болон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд шаардлагатай санхүүжилтийг хангаснаар улс орны нийгмийн асуудлыг шийдэх боломжийг нэмэгдүүлнэ.

Тиймээс Монгол Улсын ХХОАТ-т ногдох орлогын эх үүсвэрүүдийг олон улсын туршлагатай харьцуулан судалж, татвар ногдох орлогын ангилал, хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг оновчтой тодорхойлох чиглэлээр олон улсын туршлагаас суралцан ХХОАТ-т орлогын эх үүсвэрүүд бүрэн хамрагдаж буй эсэх, мөн боломжит эх үүсвэрүүдийг тодорхойлж санал, зөвлөмж дэвшүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Судлагдсан байдлын тойм

ХХОАТ-ын судалгааны чиг хандлага нь орлогын дахин хуваарилалт, эдийн засгийн өсөлт, орлогын бүрдүүлэлтэд үзүүлэх татварын бодлогын нөлөөллийг голчлон судлахад оршиж байна. Олон улсын түвшинд Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн

банк, бусад судалгааны байгууллага болон судлаачдын хийж гүйцэтгэсэн хэд хэдэн судалгааны ажил байгаа хэдий ч Монгол Улсад олон нийтэд нээлттэй судалгааны ажлууд үгүй тул тус сэдвийг судлах шаардлагатай юм.

ОУВС-гийн хэд хэдэн судалгаа байдгаас “Өндөр хөгжилтэй орнуудын татварын бодлого болон эдийн засгийн өсөлт хоорондын хамаарал” судалгаагаар ажил хөдөлмөрийн орлогод ногдуулах татварын хэмжээг бууруулснаар эдийн засгийн өсөлт, ялангуяа бага, дунд орлоготой ажилчдын өсөлтийг дэмжих боломжтой болохыг тогтоосон байдаг. Тодруулбал, ажил хөдөлмөрийн орлогод ногдох татварын хувь хэмжээг 1 хувиар нэмэгдүүлэхэд нэг хүнд ногдох ДНБ-ийг 0.4 хувиар бууруулж байсан байна (ОУВС, 2001).

Харин Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас татварын бодлогын орлогын тэгш бус байдалд үзүүлэх нөлөөллийг судалсны үр дүнд татварын бодлого нь орлогын тэгш бус байдалд ихээхэн нөлөөлдөг бөгөөд өндөр орлоготой хүмүүст өндөр татвар ногдуулах татварын тогтолцоо нь орлогын тэгш бус байдлыг багасгадаг бол эсрэгээрээ бага орлоготой хүмүүст өндөр татварын хувь хэмжээ ногдуулдаг тогтолцоо нь орлогын тэгш бус байдлыг улам нэмэгдүүлдэг гэсэн байна (OECD, 2011). Гэвч Эдийн засгийн судалгааны үндэсний товчоо (NERB)-ны судалгаагаар өндөр орлоготой хүмүүс, бага орлоготой хүмүүсээс илүүтэйгээр татвараас зайлсхийх хандлагатай байдаг гэж үзсэн байна (NERB). Тус судалгаанд мөн татвараас зайлсхийх хандлагаас үүдэн АНУ-д гэхэд жил бүр ойролцоогоор 450 тэрбум ам.долларын татварын орлогын алдагдал үүсдэг болохыг тооцоолжээ.

Энэ мэт олон улс дахь татварын бодлогын нөлөөллийг тодорхойлсон төрөл бүрийн судалгаа байдаг хэдий ч эсрэгээрээ татварын бодлогод нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж буй судалгааны ажлууд ховор байна.

Сэдвийн судлагдсан байдлаас харахад ХХОАТ нь эдийн засаг, орлогын тэгш бус байдал, татвараас зайлсхийх хандлагаас үүдэн Засгийн газрын татварын орлогын алдагдал үүсэх, мөн олон улсын өрсөлдөх чадвар зэрэгт нөлөөлдөг тул ХХОАТ-ын эх үүсвэрүүд болон тэдгээрт ногдох хувь хэмжээ нь дурын нэг тоо, эсвэл бусад улс орноос шууд хуулбарласан байж болохгүй ба Монгол Улсын нөхцөл байдалд энэ чиглэлийн судалгаа шинжилгээ болон онолын үндэслэл нь үйлчилж байгаа эсэхийг тодорхойлохоос гадна ХХОАТ-т нөлөөлөх бүх хүчин зүйлсийг нарийн судалж, шинжилсний үр дүнд илүү оновчтой, үр ашигтай байж болох ХХОАТ-ын эх үүсвэрүүд болон тэдгээрийн хувь хэмжээг тодорхойлохыг зорих нь чухал юм.

Иймд Монгол Улсын ХХОАТ-ын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн дүгнэж, онол болон олон улсын туршлагад үндэслэн тулгамдаж буй асуудлыг илүү сайжруулах алхам замыг олж, нээхэд энэхүү судалгааны гол зорилго оршино.

Судалгааны хүрээ, арга зүй

Судалгааны хүрээнд Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан дараах 6 төрлийн орлогын татварыг хамруулж, Монгол Улсын өгөгдөл, олон улсын жишигт харьцуулалтуудыг ашиглалаа. Үүнд:

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;
2. Үйл ажиллагааны орлого;
3. Хөрөнгийн орлого;
4. Хөрөнгө борлуулсан, хөрөнгө шилжүүлсний орлого;
5. Шууд бус орлого;
6. Бусад орлого.

Судалгааг кейс судалгаа болон баримтын шинжилгээний аргуудыг ашиглан боломжит тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн гүйцэтгэсэн болно.

Судалгааны тайлангийн бүтэц

Энэхүү судалгааны тайланг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа. Үүнд:

- Олон улсын түвшинд ашиглагддаг ХХОАТ-ын зарчмууд болон улс орнуудын сайн туршлагыг хоёрдугаар бүлэгт,
- Монгол Улсад хэрэгжиж буй ХХОАТ-ын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, дүгнэлтийг гуравдугаар бүлэгт,
- ХХОАТ ногдуулах орлогын эх үүсвэрийн ангилал тус бүрийн санхүү, зохицуулалтын үүргийн хэрэгжилт, тэдгээрт тулгарч буй асуудлуудыг дөрөв болон тавдугаар бүлэгт,
- Олон улсад хэрэгжиж буй ХХОАТ-тай холбоотой хууль тогтоомж болон дүрэм журамтай танилцаж, тэдгээрийн туршлагаас хэрэгжүүлж болох анхаарах асуудлуудыг зургаадугаарт бүлэгт тус тус тодорхойлов. Мөн судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын ХХОАТ-ын эх үүсвэрийг илүү оновчтой болгоход чиглэсэн санал, дүгнэлтийг дэвшүүлэв.

Судалгааны ажлыг баримтын болон кейс шинжилгээний аргуудыг ашиглан, ХХОАТ-ын тухай хууль болон бусад холбогдох нээлттэй мэдээлэлд үндэслэн “Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн судалгааны баг (Зөвлөх А.Батпүрэв, судлаач Б.Цэлмэг, Г.Ариунзаяа, Д.Болортуяа нар) гүйцэтгэлээ.

II. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРЧМУУД

Энэ хэсэгт одоогийн Монгол Улсын ХХОАТ-ын орчинд үнэлэлт, дүгнэлт хийхийн тулд онол болон олон улсын түвшинд сайн ХХОАТ-ын зарчмыг тодорхойлов. Ингэхдээ Адам Смитын татварын үндсэн 4 зарчим болон бусад эрдэмтдийн онол, Эстони, Герман, Япон Улсын жишээг ашиглав.

Ямар шалгуур үзүүлэлтээр ХХОАТ-ыг сайн гэж дүгнэх вэ?

1776 онд Шотландын эдийн засагч, санхүүч Адам Смит “Үндэстнүүдийн баялаг” номдоо татварын үндсэн 4 зарчмыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- 1. Эрх тэгш, шударга буюу төлбөрийн чадварт тохирсон байх зарчим.** Энэ нь татвар төлөгч иргэн бүр татвараа шударгаар төлөх ёстой бөгөөд төлөх татварын хувь хэмжээг Засгийн газраас хүн бүрд ижил тэгш байхаар тогтоож өгөх ёстойг илтгэж байдаг. Ингэхдээ ХХОАТ нь татвар төлөгчдийн орлогын хэмжээтэй уялдаатай, төлөх боломжтой, тохиромжтой байх ёстой. Ингэснээр татвар төлөгчийн эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд хүндрэл учруулахгүй байх боломж бүрдэх юм.
- 2. Тохиромжтой байх зарчим.** Татвар төлөгчдөд таатай, захиргааны дарамтыг багасгах хэлбэрээр албан татварыг ногдуулах ёстой. Татвар тогтоох үйл явц нь нь эдийн засгийн аливаа үйл ажиллагаа болон татвар төлөгчдөд шаардлагагүй зардал гаргахгүй байхаар төлөвлөх нь зүйтэй.
- 3. Тодорхой байх зарчим.** ХХОАТ ногдуулах орлогын эх үүсвэрийн төрөл, ангилал, тэдгээрийн төлөх хэлбэр, хугацаа, болон хувь хэмжээ зэрэг нь татвар төлөгчдөд маш тодорхой бөгөөд ойлгомжтой байж татвар төлөхөд хялбар тогтолцоог бүрдүүлсэн байх ёстой.
- 4. Үр ашигтай байх зарчим.** Татвар нь эдийн засгийн өсөлтийг дэмжихүйц, үр ашиг болон бүтээмжийг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлэх ёстой.

Дээрх 4 зарчмаас гадна бусад эрдэмтдийн үзэж буйгаар татварын заавал агуулах ёстой хэд хэдэн зарчим, онол мөн байдаг. Тухайлбал,

- ✓ **Хүрэлцээтэй байх зарчим.** Татвар нь төрөөс иргэдэд үзүүлэх дэд бүтэц, эрүүл мэнд, боловсрол зэрэг үйлчилгээ, төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд хангалттай хэмжээний орлогыг бүрдүүлэх ёстой.
- ✓ **Уян хатан байх зарчим.** Татварын тогтолцоо нь өөрчлөн шинэчлэгдэж буй эдийн засгийн нөхцөл байдал, гэнэтийн үйл явдалд дасан зохицож, хариу арга хэмжээ авахад хялбар байх ёстой.

- ✓ **Олон талт байдлын зарчим.** Нэг татвараас хараат бүс байхын тулд татварын орлогыг олон төрлийн эх үүсвэрээс бүрдүүлэх ёстой. Ингэснээр татварын орлогыг тогтворжуулахад тусалдаг.
- ✓ **Ил тод байх зарчим.** Татварын орлогыг захиран зарцуулах, төлөвлөлт болон ашиглалт нь татвар төлөгчдөд ил тод байх ёстой. Ингэснээр хариуцлагыг нэмэгдүүлж, авлига, хээл хахуулийг бууруулан, татвар төлөгчдийн төрд итгэх итгэл нэмэгдэж, татварт хандах эерэг хандлага бий болдог.
- ✓ **Захиргаанд нийцэх зарчим.** Татварын хууль, дүрэм нь захиргааны бүтцэд тохирсон, хэрэгжих боломжтой байх ёстой. Нарийн төвөгтэй зохицуулалт нь захиргааны зардлыг ихэсгэж, зөрчил болон асуудал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байдаг.

УЛС ОРНУУДЫН САЙН ТУРШЛАГА

1. Эстони Улс

Эстони Улсын татварын системийг олон улсад татварын бодлогын сайн жишээ гэж тодорхойлдог бөгөөд Олон улсын татварын өрсөлдөх чадварын индексээр сүүлийн 8 жилийн хугацаанд дараалан 1-рт эрэмбэлэгдсээр ирсэн татварын систем юм¹. Тус улсын татварын бодлого нь энгийн байдал, өрсөлдөхүйц татварын хувь хэмжээ, өргөн татварын бааз суурь, гадаадын хөрөнгө оруулалтыг татахуйц, эдийн засгийн өсөлт, инновацыг дэмжих зэргийг хослуулсан сайн татварын тогтолцоо гэж тодорхойлж болно. Уг татварын сайн жишээ нь дараах хэд хэдэн зарчмаар тодорхойлогдож байна. Үүнд:

- **Татварын пропорциональ хувь хэмжээ:** Эстони Улс өмнө нь нарийн төвөгтэй дүрмүүдээс бүрдсэн шаталсан татварын тогтолцоотой байсан бол 1994 онд ХХОАТ болон аж ахуй нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) аль алинд нь жигд татварын хувь хэмжээг (20 хувь) нэвтрүүлсэн байдаг. Ийнхүү татварын ачааллыг бууруулснаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөрлөх, хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалт хийх хөшүүргийг бий болгож, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах боломжийг олгодог.
- **Энгийн, ойлгомжтой байдал ба ил тод байдал:** Татварын нарийн төвөгтэй зохицуулалт, өсөн нэмэгдэх хувь хэмжээ байхгүй байгаа нь захиргааны ачааллыг бууруулж, төвөгтэй байдлыг багасгадаг гэж үздэг.
- **Татварын удирдлагын үр дүнтэй байдал:** Татварын байгууллагын ачаалал бага байгаа нь татварын хэрэгжилтийг дэмжиж, татвараас зайлсхийх боломжийг багасгадаг. Мөн дижитал шийдэл, цахим засаглал нь татварын үйл явцыг улам боловсронгуй болгож, бичиг цаасны ажлыг багасгаж, татвар төлөгч болон татварын албаны хоорондын харилцааг хялбаршуулж чадсан байна.
- **Татвар ногдох эх үүсвэрийн хамрах хүрээ өргөн, ойлгомжтой:** Татварын хувь хэмжээ бага, пропорциональ хэмжээтэй боловч Эстони улс орлогын ихэнх эх үүсвэрийг багтаасан татварын өргөн бааз суурьтай. Энэ нь татвараас зайлсхийх эрсдэлийг багасгаж, татварын орлогын тогтвортой урсгалыг хадгалж, Засгийн газрын зардлыг дэмжинэ.
- **Татвар ногдуулах орлого:**

¹ Олон улсын татварын өрсөлдөх чадварын индекс, Tax Foundation, 2022

Оршин суугч татвар төлөгч

1. Хөдөлмөр эрхлэлтийн орлого;
2. Бизнесийн орлого;
3. Эд хөрөнгө шилжүүлснээс олсон орлого;
4. Ногдол ашиг, хүү, түрээсийн төлбөр;
5. Оюуны өмчөө ашиглуулсны төлбөр;
6. Тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, тодорхой шагнал, сугалааны хонжвор;
7. Даатгалын нөхөн төлбөр, тэтгэврийн сангаас олгох төлбөр;
8. Бага татвартай харьяалалд байрладаг хуулийн этгээдийн орлого (өөрөөр хэлбэл, CFC²-ийн орлого орно).

Оршин суугч бус татвар төлөгч:

1. Эстони дахь хөдөлмөрийн гэрээ эсвэл гэрээлэгчийн гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын орлого;
 2. Эстони дахь бизнесээс олсон орлого;
 3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;
 4. Эстонид байрлах хөрөнгийн түрээсийн орлого;
 5. Эстонид байрлах хөрөнгийг захиран зарцуулахаас олох ашиг;
 6. Эстони дахь аж ахуйн нэгжийн төлсөн захирлуудын урамшуулал;
 7. Эстони дахь үйл ажиллагаанаас спортын тамирчин эсвэл уран бүтээлчийн олсон орлого;
 8. Тэтгэвэр, тэтгэлэг.
- ✓ **Бага хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого:** Эстони Улсын татварын систем нь хязгаарлагдмал тооны чөлөөлөлттэй бөгөөд энэ нь татварын бааз суурийг өргөн хэвээр нь хадгалж, нарийн төвөгтэй байдлыг багасгахад тусалдаг.

2. Герман Улс

ХБНГУ-ын татварын бодлого нь шаталсан татвар, шударга бүтэц, иж бүрэн бааз суурь, нийгмийн халамж, төрийн үйлчилгээг дэмжих, зорилтот хөнгөлөлтийн бодлого, тогтвортой байдал, үр ашигтай удирдлагаар тодорхойлогддог сайн татварын тогтолцооны жишээ юм.

- ✓ **Шаталсан, шударга тогтолцоо.** ХБНГУ-ын татварын бодлого нь өндөр орлоготой иргэд өндөр татвар төлдөг орлогын албан татварын шаталсан тогтолцоотой бөгөөд энэ бүтэц нь баялгийг дахин хуваарилах, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг дэмжих замаар тэгш байдлыг бий болгодог гэж үздэг.

² Controlled foreign corporation (CFC) нь өөр улс оронд бүртгэлтэй аж ахуйн нэгжийг хэлнэ.

- ✓ **Иж бүрэн татварын суурь бааз.** ХБНГУ-ын татварын систем нь ажил эрхлэлтийн орлого, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн орлого, хөрөнгийн өсөлт, түрээсийн орлого зэрэг орлогын өргөн хүрээг хамардаг. Энэхүү иж бүрэн татварын суурь нь татвараас зайлсхийх нөхцөлийг багасгаж, улсын орлогод хувь нэмэр оруулах боломжийг олгодог. Үүнд:
 1. Хөдөө аж ахуй ба ойн аж ахуй
 2. Худалдаа болон бизнес
 3. Бие даасан мэргэжлүүд
 4. Ажил эрхлэлт
 5. Капитал хөрөнгө оруулалт
 6. Түрээс, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
 7. Хуульд заасан бусад орлого
- ✓ **Нийгмийн халамж, нийтийн үйлчилгээ.** Татварын орлого нь нийгмийн халамжийн хөтөлбөр, эрүүл мэнд, боловсрол, олон нийтийн дэд бүтцийг санхүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.
- ✓ **Хөнгөлөлт ба чөлөөлөлт.** Нийгэм, эдийн засгийн өргөн хүрээтэй, тодорхой зорилгод нийцсэн янз бүрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлдэг. Тухайлбал, хүүхэд асрах хугацаанд болон боловсролын зардалд хөнгөлөлт үзүүлэх нь өрхийн санхүүгийн дарамтыг хөнгөвчилдөг байна. Мөн инновац, технологийн дэвшлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хадгалахын тулд судалгаа шинжилгээний зардалд татварын хөнгөлөлт үзүүлдэг.
- ✓ **Татварын тогтвортой байдал.** ХБНГУ-ын татварын бодлогын тогтвортой байдал нь татвар төлөгчид болон хөрөнгө оруулагчдад тодорхойгүй байдал үүсэхээс сэргийлж, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлдэг.
- ✓ **Үр ашигтай татварын удирдлага.** ХБНГУ-ын татварын алба нь үр ашигтай, үр дүнтэй гэдгээрээ алдартай. Хялбаршуулсан үйл явц, дижитал шийдэл, үр дүнтэй хэрэгжүүлэх механизмууд нь орлого бүрдүүлэлтэд ихээхэн хувь нэмэр оруулдаг.

3. Япон Улс

Япон Улсын ХХОАТ-ын систем нь хувь хүмүүсийн санхүүгийн олон төрлийн нөхцөл байдлыг харгалзан үздэг ба тэдгээрийг дэмжихэд чиглэсэн шаталсан татварын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлт, тусгай заалтуудыг хослуулсан байдаг.

- ✓ **Шаталсан тогтолцоо.** Япон Улс өндөр орлоготой иргэдэд илүү өндөр татвар ногдуулдаг шаталсан татварын тогтолцоотой ба орлогын ялгаатай түвшинтэй иргэдийнхээ татварын дарамтыг бууруулах зорилгоор хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг мөн хослуулан хэрэгжүүлдэг байна.

- ✓ **Татварын суурь бааз.** Япон Улсын ХХОАТ нь нийт орлогуудыг үндсэн 10 төрөлд хувааж, тэдгээрийн татвар ногдуулах аргачлалыг нь тус тусад нь зааж өгч, 9-45 хувиар татвар ногдуулдаг. Үүнээс цалин хөлсний орлогод 7 шатлалтайгаар 5-45 хувиар татвар ногдуулдаг байна. Тус улсын ХХОАТ-т ногдох эх үүсвэр нь дараах бүтэцтэй байна. Үүнд:
 1. Цалин, хөдөлмөрийн хөлсний орлого
 2. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн орлого
 3. Хөрөнгө оруулалтын орлого
 4. Тэтгэвэр, тэтгэмж
 5. Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн орлого
 6. Гадаад улсын эх үүсвэрээс олсон орлого
 7. Бусад орлого
- ✓ **Татвар төлөх хэлбэр.** Татвар төлөгчид татвараа өөрсдөө мэдүүлж төлдөг. Татварын алба нь татвар төлөгч тус бүрд зориулж өөр өөр стандарт, нэгдсэн мэдүүлгийн маягыг гаргаж өгдөг. Энэ нь татвар төлөгчдөд мэдлэг түгээх, татвараа зөв тооцоолоход түлхэц болдог бөгөөд хяналт шалгалтыг сайжруулах, татвар хураалт, менежментийн үр ашгийг дээшлүүлэх, зардлыг хэмнэхэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг.
- ✓ **Санхүү, төсвийн бүрдүүлэлт.** Японы орлогын албан татварын орлогыг тус улсын Засгийн газар удирдан зарцуулдаг бөгөөд ХХОАТ нь улсын татварын орлогын 35.1 хувийг бүрдүүлж байгаа нь Японы хамгийн том татварын нэг гэдгийг харуулж байна.

Япон Улсын ХХОАТ-ын онцлог, давуу тал

- ✓ **Нийгмийн халамж, нийтийн үйлчилгээ.** Эрүүл мэндийн даатгал, тэтгэврийн шимтгэлийг татвараас хасаж, татвар ногдуулах орлогыг бууруулдаг ба татварын орлого нь татвар төлөгч иргэд ирээдүйд тодорхой болон тодорхой бус нөхцөл (ажилгүйдэл, хөгжлийн бэрхшээл, тэтгэвэрт гарах) байдалтай тулгарсан тохиолдолд санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлдэг Япон улсын нийгэм хамгааллын тогтолцоог дэмждэгээрээ онцлогтой.
- ✓ **Хөнгөлөлт ба чөлөөлөлт.** Татварын тогтолцоо нь татвар төлөгчдөд татвар ногдуулах орлогоо бууруулахын тулд янз бүрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг зөвшөөрдөг. Тухайлбал, ажил эрхлэлттэй холбоотой зардал, эмчилгээний зардал, орон сууцны зээлийн хүүгийн төлбөр багтдаг байна. Мөн түүнээс гадна хөнгөлөлт, чөлөөлөлт нь гэр бүл, ялангуяа хэн нэгнийг асран хамгаалдаг айл өрхөд санхүүгийн хөнгөлөлт үзүүлж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, өндөр настныг асрахтай холбоотой санхүүгийн ачааллыг бууруулахад тусалдаг.

- ✓ **Хөрөнгө оруулалтыг дэмжих.** Татварын тодорхой заалтууд болон хөнгөлөлтүүд нь тодорхой салбаруудад хөрөнгө оруулалт хийхийг дэмжиж, эдийн засгийн өсөлт, инновацыг бий болгоход чухал үүргийг гүйцэтгэдэг.

Дээрх онолын болон олон улсын туршлагын хүрээнд сайн ХХОАТ-ыг тодорхойлж буй зүйлсээс нэгтгэн дүгнэж, ХХОАТ-ыг үнэлэх шалгуур үзүүлэлт, тэдгээрийг хэмжих зарчмыг дараах байдлаар тодорхойлж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ХХОАТ-ыг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Дэд шалгуур үзүүлэлт	Хэмжих зарчим
1	Шударга байх	Иргэн бүр татвар төлөх	Иргэн бүр өөрт ногдох албан татварыг цаг тухайд нь төлдөг эсэх (Үүнд, татвараас зайлсхийх түвшин)
		Төлбөрийн чадварт тохирсон байх	ХХОАТ-ын ачаалал их байгаа эсэх (ХХОАТ/ДНБ)
2	Тохиромжтой байх	Иргэдийн санхүүгийн нөхцөлд тохирсон байх	
3	Тодорхой байх	Эх үүсвэрүүд	1. Орлогын эх үүсвэрийн суурь бааз хамрах хүрээ хангалттай эсэх, 2. Энгийн ойлгомжтой, хялбар эсэх
		Төлөх хувь хэмжээ	Энгийн ойлгомжтой, хялбар эсэх
		Төлөх хэлбэр	
		Төлөх хугацаа	
4	Үр ашигтай байх	Санхүү, төсвийн үүрэг	ХХОАТ-ын төлөвлөгөөний биелэлт
		Зохицуулалтын үүрэг	Хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт. Тухайлбал, эдийн засгийн өсөлтийг дэмжиж буй эсэх
		Нийгмийн үүрэг	1. Орлогын тэгш бус байдлыг бууруулж буй эсэх, 2. Боловсрол, эрүүл мэндийг дэмжиж буй эсэх.


Эх сурвалж: Судлаачдын дүгнэлт

III. НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

3.1 Монгол Улсын татварын орчин

Монгол Улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжсэнээр анх Албан татварын тухай хууль, түүнчлэн 1992 онд татварын багц хуулийг баталж, 1993 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс анхлан мөрдөж эхэлснээр татварын тогтолцооны эхлэл тавигдсан байна.

График 1. ДНБ-д татварын орлогын эзлэх хувь хэмжээ, улс орнуудаар, 2021 он



Эх сурвалж: OECD (2021 он)

2021 оны байдлаар Монгол Улсын татварын орлогын ДНБ-д эзлэх хувь 25 хувьд хүрсэн нь хөгжингүй орнуудтай харьцуулахад бага ч, бусад харьцуулагдахуйц улс орнуудаас өндөр байгаа нь Монгол Улсын татварын ачаалал³ харьцангуй өндөр болохыг харуулж байна. Нөгөө талаас татварын суурийг хангалттай тэлж чадахгүй байгаа энэ үед шударга татвар төлөгч байгууллага, хувь хүнд ирэх татварын ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй юм. Иймээс татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхээс илүүтэй татвар ногдох эх үүсвэрийн хамрах хүрээ, үндсэн бааз суурийг нэмэгдүүлэх асуудалд анхаарах нь илүү үр дүнтэй байна.

³ Татварын ачаалал - ДНБ-д эзлэх татварын орлогын хэмжээ бөгөөд тус үзүүлэлтээр тухайн улсын төсвийн тогтвортой байдал, татварын үр ашиг, төрийн оролцоо зэргийг харуулах боломжтой.

График 2. Монгол Улсын татварын орлого, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2020 он



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

Татварын орлого бүрдүүлэлтийг эдийн засгийн салбараар ангилан харвал, Уул уурхай (40.9 хувь), Бөөний болон жижиглэн худалдаа (12.2 хувь), Боловсруулах үйлдвэрлэл (9 хувь), Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (7.6 хувь) гэсэн 4 салбар нийт татварын 70 гаруй хувийг бүрдүүлж байна. Нөгөө талд ДНБ-ий 13.1 хувийг бүрдүүлдэг, ажиллах хүчний 3 хүний 1 нь ажилладаг хөдөө аж ахуйн салбар нийт татварын орлогын 0.2 хувийг л бүрдүүлж байгаа нь татвар хураалт хангалтгүй салбарууд одоог хүртэл байсаар байгааг харуулж байна.

3.1.1 Татварын үндсэн үүрэг, тэдгээрийн Монгол Улс дахь хэрэгжилт

1. Санхүүгийн үүрэг. Монгол Улсын төсөвт үзүүлэх нөлөө

Сүүлийн 5 жилийн дунджаар Монгол Улсын төсвийн орлогын 86.5 хувийг татварын орлого бүрдүүлж ирсэн бөгөөд үүнээс татвар нь төсвийг бүрдүүлэгч гол арга хэрэгсэл гэдэг утгаар төрийн бодлого түүний хэрэгжилтэд чухал нөлөөтэй юм.




График 3. Монгол Улсын төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэл, 2020-2022 он

Төсвийн зардал өндөр, татварын хувь хэмжээ бага боловч хөнгөлөлт, чөлөөлөлт олонтой Монгол Улсын хувьд төсвийн тэнцэл сүүлийн 10 жилийн хугацаанд (2018 оныг эс тооцвол)


Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тодотгол

алдагдалтай гарсаар ирсэн. Төсвийн гүйцэтгэлийн хувьд төлөвлөгөөнөөс тасрах зүй тогтол ажиглагддаг бол 2021 онд дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ, эрэлт нэмэгдэж, улмаар уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн экспорт сайжирснаар төсвийн орлогын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлсөн.

Үүнээс Монгол Улсын татварын санхүү, төсвийн үүргийн хэрэгжилт сул байна гэж дүгнэх боломжтой юм.

Улсын нэгдсэн төсвийн татвар, хураамжийн орлого. Татварын нийт орлого 2022 оны гүйцэтгэлээр 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 37.8 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс татварын орлогын дийлэнх хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар (25 хувь), нийгмийн даатгалын орлого (19 хувь), аж ахуй нэгжийн орлогын албан татвар (17 хувь) болон хувь хүний орлогын албан татвар (9 хувь) тус тус бүрдүүлсэн байна.

График 4. Төсвийн орлогын бүтэц, бүс нутгуудаар, 2022 он




Эх сурвалж: OECD (2022 он)

OECD-ийн гишүүн орнууд буюу харьцангуй хөгжингүй улсуудын хувьд төсвийн орлогын 24 орчим хувийг ХХОАТ бүрдүүлж байгаатай харьцуулахад Монгол Улсын ХХОАТ-ын төсвийн бүтцэд эзлэх хувь 2 дахин бага байна. Энэ ялгаанд мэдээж орлогын түвшин, эдийн засгийн төрөлжсөн байдал нь татварын бааз сүүрийг нэмэгдүүлж байдагтай холбоотой. Нөгөө талаас татварын оновчтой бодлого, үр ашигтай хэрэгжүүлэх механизм, дагаж мөрдөх түвшин өндөр байгаагаар тайлбарлаж болно.

2. Зохицуулалтын үүрэг: Татварын бодлогоор эдийн засгийн өсөлтийг дэмжих нь

ХХОАТ-ын зөв зарцуулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж, үлс орны хөгжилд томоохон нөлөө болох учиртай. Мөн эргээд эдийн засгийн өсөлт өндөр байх нь аж ахуйн нэгжийн ашиг орлого, хөдөлмөр эрхлэгчдийн цалин болон түүнтэй адилтгах орлогын хэмжээг өсгөж байдаг. Тухайлбал, Монгол Улсын ХХОАТ-т цалин, хөдөлмөрийн хөлсний орлогын эзлэх хувь дунджаар 70-75 хувь байдаг ба эдийн засгийн өсөлт болон ХХОАТ нь хоорондоо эерэг хамааралтай байна.

График 5. Монгол Улсын төсвийн зардлын бүтэц, 2021 ба 2022 он
(нийт зардалд эзлэх хувиар)




Эх сурвалж: ҮСХ (2022 он)

2022 оны байдлаар Монгол Улсын Засгийн газрын төсвийн зардлын бүтцийн 64 хувийг урсгал зардал, 26.5 хувийг хөрөнгийн зардал бүрдүүлсэн байна. Гэвч урсгал зардлаас илүүтэйгээр хөрөнгийн зардлаа нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд, тогтвортой дэмжих сайн талтай байдаг бол урсгал зардлыг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг богино хугацаанд дэмжих хэдий ч урт хугацаанд сөрөг нөлөөтэй байдгийг анхаарч үзэх нь зүйтэй юм⁴.

Нийгмийн үүрэг: Нийгмийн хэрэгцээ, сайн сайхан байдлыг хангах нь

Орлогын тэгш бус байдал. 2020 оны байдлаар Монгол Улсын Жини коэффициент 0.32 байгаа нь бусад дунд орлоготой орнуудтай харьцуулахад 20 орчим хувиар бага хэдий ч сүүлийн 10 жилийн хугацаанд харьцангуй тогтвортой түвшинд хадгалагдсаар байна. Монгол Улсын ХХОАТ нь орлогын тэгш бус байдлыг бууруулахад нөлөө үзүүлдэг эсэхийг судлахад, татварын хувь хэмжээ пропорциональ хэдий ч татварын орлогын голлох хэсгийг өндөр орлоготой иргэд бүрдүүлдэг буюу харьцангуй прогрессив шинжтэй бөгөөд үүнд улсаас олгож буй тэтгэвэр, тэтгэмж голлох хувийг бүрдүүлж буй нь нөлөөлж байна. Түүнчлэн, нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь орлогын ялгаанаас үл хамааран жигд тархсан байгаа нь тэгш бус байдал буурахад сөргөөр нөлөөлж байна.⁵

График 6. Монгол Улсын Жини индекс⁶



Эх сурвалж: Дэлхийн банк, ҮСХ

⁴ Rosoiu, Iulia, The impact of the current and capital expenditure on the economic growth in Romania, Paris 2015 он.

⁵ Орлогын тэгш бус байдлыг бууруулахад ээлтэй татварын бодлого, Ц.Бямбацогт, 2022 он.

⁶ Жини индекс – Энэхүү индекс нь аливаа эдийн засаг дахь хувь хүн, айл өрхийн орлого, хэрэглээний хуваарилалтын тэгш бус байдлыг үнэлдэг. Ингэхдээ 0 байх нь төгс тэгш хуваарилалтыг илтгэх бол, 100 нь төгс тэгш бус байдлыг илтгэдэг буюу уг индекс их байх тусам орлогын тэгш бус байдал их байгааг илтгэнэ.

Боловсролын салбарт зарцуулж буй төсвийн зардал

Улсын нэгдсэн төсвийн нийт зардалд боловсролын зардлын эзлэх хувь 2017-2020 оны хооронд дунджаар 13.9 хувьтай байсан ба энэ нь бусад дундаж орлоготой орнуудтай харьцуулахад ойролцоо түвшинд байна. Гэвч боловсролын зардлын эзлэх хувь 2021 онд 3.5 хувь хүртэл буурчээ.

Боловсролын хүртээмж ба тэгш хамрах сургалт дээр ихээхэн ахиц дэвшил гарсаар байна. Тухайлбал, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 82.8 хувь, суурь боловсролын хамран сургалт 91.6 хувьтай байна. Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, сул зохион байгуулалт нь зарим бүс нутагт ашиглагдаагүй хөрөнгө үлдэх боломжийг олгож байхад бусад бүс нутагт нөөцийн ихээхэн хомсдол үүсгэхэд хүргэж байна (Дэлхийн банк, 2018).

Эрүүл мэндийн салбарт зарцуулж буй төсвийн зардал

Улсын нэгдсэн төсвийн нийт зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2017-2021 оны хооронд дунджаар 7 хувьтай байсан ба энэ нь бусад дундаж орлоготой орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байна. Харин 2022 онд тус зардлын төсөвт эзлэх хувь 2.9 хувь болж буурчээ. Тус салбарын төлөвлөлт дунд болон урт хугацааны тодорхой стратеги дээр үндэслээгүй байгаа нь хөрөнгө оруулалтын болон үрсгал зардлын чанар, үр ашигт сөргөөр нөлөөлж байна (Дэлхийн банк, 2018).

3.2 Монгол Улсын ХХОАТ-ын тогтолцоо


ХХОАТ нь дунджаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 10 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд нийгэм, эдийн засгийн хүрээнд төрийн үйлчилгээ, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай санхүүжилтийг бий болгох, мөн орлогын тэгш байдал, ажиллах хүчний оролцоо, эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангахад нөлөөлж байдаг.

3.2.1 ХХОАТ ногдуулж буй орлогын эх үүсвэрийн танилцуулга, бусад улс оронтой харьцуулсан байдал

Монгол Улсын ХХОАТ-ын тухай хууль (2019 оны гуравдугаар сарын 22-ны өдрийн шинэчилсэн найруулга)-д зааснаар нийт 6 бүлэг бүхий орлогын эх үүсвэрт ХХОАТ ногдуулж байна. Үүнд:

- i. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;
- ii. Үйл ажиллагааны орлого;
- iii. Хөрөнгийн орлого;
- iv. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;
- v. Шууд бус орлого;
- vi. Бусад орлого.

Зураг 1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд тусгагдсан албан татвар ногдох орлого



Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль


Монгол Улсын ХХОАТ ногдох орлогын эх үүсвэрийг олон улсын түвшинд харьцуулалт хийхэд, нийтлэг хандлага нь хөдөлмөр эрхлэлтийн орлого, бизнесийн орлого, хөрөнгө шилжүүлсний орлого, ногдол ашгийн орлого, түрээсийн орлого, хүүгийн орлого гэсэн орлогын төрлүүдийг Хүснэгт 7-д харуулсан бүх улс орлогын эх үүсвэрт тооцож байна. Гэсэн хэдий ч улс орон бүр татварын тогтолцоондоо өөрийн гэсэн онцлогтой, тэргүүлэх чиглэлтэй байна. Тухайлбал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын зорилтыг тусгасан, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн тодорхой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн тусгай заалтууд мөн ажиглагдаж байна.

Хүснэгт 2. Хувь хүний орлогын албан татвар ногдуулж буй орлогын эх үүсвэрүүд, улс орнуудаар

	Монгол Улс	БНХАУ	АНУ	Их Британи	Швед	Австрали	Сингапур	Япон	Турк	Эстони
Хөдөлмөр эрхлэлтийн орлого	+	+	+	+	+	+	+	+	+	+
Өмчийн нөхөн олговор		+	+	+	+	+	+	+	+	
Хөдөлмөрийн үйлчилгээний орлого		+								
Бизнесийн орлого	+	+	+	+		+	+	+	+	+
Хөрөнгө шилжүүлсний орлого	+	+	+	+	+	+		+	+	
Ногдол ашгийн орлого	+	+	+	+		+	+	+	+	
Түрээсийн орлого	+	+	+	+	+	+	+	+	+	+
Хүүгийн орлого	+	+	+	+		+	+	+	+	
Оюуны өмчийн орлого (IP)		+		+						
Тус улсад ажиллахаар ирсэн оршин суугч бус ажилчдын тэтгэмж (OWR)				+						
Холбогдох гадаад орлого (RFI)				+		+				
Оршин суугч бус хүний хөрөнгө оруулалтын орлого				+				+		
Хувь хүний хадгаламжийн данснууд (ISAs)				+						
Хамаарал бүхий компаниас олсон орлого					+					
Хөрөнгө оруулалтын орлого					+					+
Гадаад валютын солилцоо					+	+				
Санхүүгийн хэлцлүүд						+				
Оюуны өмчөө ашиглуулсны төлбөр										+

Эх сурвалж: Worldwide Tax Summaries (2023 он)

График 7. Монгол Улсын ХХОАТ ногдуулах эх үүсвэрүүд, эзлэх хувиар (2018-2022 он)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар (2022 он)

ХХОАТ-ын тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгө ба хөрөнгө борлуулсны болон бусад бүх орлогыг татварын суурьт хамруулан татвар төлөхөөр заасан хэдий ч ХХОАТ-ын орлогын 70-75 хувийг нь зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого бүрдүүлж, үйл ажиллагааны орлогоос төлсөн татварын дүн 4-6 хувийг эзэлж байгаагаас үзэхэд бусад төрлийн орлого олсон иргэд хангалттай татварт хамрагдахгүй, ХХОАТ-ын ачааллыг тогтмол ажлын байртай, гэрээгээр хөдөлмөр эрхэлж буй хүмүүс үүрч, татварын шударга байх зарчим хангагдаж чадахгүй байх магадлалтайг харуулж байна.

3.2.2 ХХОАТ-ын орчин дахь шинэчлэл, өөрчлөлтүүд, тэдгээрийн үр дүн

Монгол Улсад 1990 онд ХХОАТ-ын тухай хуулийн эхлэл тавигдсанаас хойш хуулийн орчин, түүний хэрэгжилтийг дэмжих зорилгоор хэд хэдэн шинэчлэл, өөрчлөлтийг хийж иржээ. Тэдгээрийн голлох өөрчлөлт болон үр дүнг доор харуулав.

Хүснэгт 3. ХХОАТ-ын тухай хуульд сүүлийн 30 жилийн хугацаанд орсон шинэчлэлт, өөрчлөлтүүд

<p>1993-2007 он</p>	<p>1993 онд ХХОАТ-ын тухай хууль хэрэгжиж эхэлснээс өнөөг хүртэлх хугацаанд, түс хуульд нийт 20-иод удаагийн өөрчлөлт, шинэчлэл хийсэн байдаг. Үүнээс хамгийн том нөлөө бүхий шинэчлэлийн нэг нь 2007 оны өөрчлөлт байв. ХХОАТ-ыг орлогын эх үүсвэрт 10, 20, 30 гэсэн өсөн нэмэгдэх хувь хэмжээ ногдуулдаг байсан бол түс өөрчлөлтөөр татварын хувь хэмжээг 1 шатлалтай болгож, жигд 10 хувь байхаар тогтоосон байдаг.</p> <p>Үр дүн: Монгол Улсын ХХОАТ-ыг энгийн бөгөөд ойлгомжтой болоход нэг алхам ойртуулсан шинэчлэл гэж дүгнэж байна. 2007 оны Дэлхийн банкны “Татварын таатай орчны судалгаа”-нд Монгол Улс 45 дугаар байранд эрэмбэлэгдэж байв.</p>
----------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

<p>2018 он</p>	<p>Монгол Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ОУВС-тай хамтарсан хөтөлбөрийн дагуу Засгийн газраас 7 төрлийн татварыг нэмэгдүүлэх шийдэл боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү 7 төрлийн татвар дотор ХХОАТ-ыг нэмэгдүүлэх буюу шатлалтай болгох шийдэл батлагдан 2018 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн боловч тун удалгүй энэ шийдэл цуцлагдан, хуучин татварын системээ дахин хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>Үр дүн: Цуцлагдсан шалтгаан нь татварын ерөнхий зарчмыг алдагдуулсан, логик үндэслэл муутай байсан төдийгүй нийгмийн дундаж давхаргад дарамт үүсгэх эрсдэлтэй шинэчлэл болсон гэж үзжээ.</p>
<p>2020 он</p>	<p>Албан татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулиар зохицуулах шаардлагатай шинэ харилцааг хуульчлах, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн нэвтрүүлэх, татварыг энгийн хялбар болгох замаар татварын суурийг өргөжүүлэх, цаашлаад эдийн засаг, бизнесийн орчныг татварын бодлогоор дэмжих зорилгоор багц хуулийн шинэчлэлийг хийж, 2020 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн байдаг. Үүнээс ХХОАТ-т хамаарах голлох өөрчлөлтүүдийг авч үзвэл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Иргэн хүн хувиараа бизнес эрхэлж, хөрөнгөө түрээслүүлж, орлого олсон бол ашгаасаа татвар төлөх боломжтой болсон. 2. Зарим хянахад төвөгтэй хөдөлмөр, бизнес эрхлэлтэд (Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн, хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн) ногдох татварын дээд, доод хэмжээг зааж өгсөн. 3. Тогтвортой, ногоон хөгжлийг дэмжих хэд хэдэн өөрчлөлт багтсанаараа мөн онцлог. Тухайлбал, агаарын бохирдлыг бууруулах ажлыг дэмжих, гол горхийг нөхөн сэргээх ажлуудыг дэмжсэн татварын хөнгөлөлтүүд нэмэгдсэн. 4. Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар тухайн аймаг, сумын нутаг дэвсгэр дээр явуулсан үйл ажиллагаанаас олсон албан татвар ногдох орлогод татварын хөнгөлөлт үзүүлэх болсон. 5. Хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна. 6. Чөлөөт уран бүтээлчид орлогоосоо зардлаа хасуулж, ашгаасаа татвар төлж болохоор зохицуулсан. <p>Үр дүн: Энэхүү шинэчилсэн багц хууль нь татвар төлөгчийн татвараа төлөх, тайлагнах үйл явцыг хялбаршуулснаас гадна төлөх татварын хэмжээний талаар өмнөх хуульд байсан зохицуулалтын хүрээг тэлсэн, зарим цөөн төрлийн хөнгөлөлтийг шинээр бий болгосон байна.</p>

2023 он

2023 онд Төсвийн тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслүүдийн хамт өөрчлөлт оруулан баталсан бөгөөд тус хуулийн төслийг боловсруулахдаа үнэт цаасны зах зээл, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих болон төсвийн орлогын шинэ их үүсвэр бий болгоход чиглэсэн зарчмуудыг баримталсан байна. Тухайлбал, ХХОАТ-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын жилийн татвар ногдуулах орлогын дүнд доорх хувь хэмжээгээр албан татвар ногдуулахаар өөрчлөлт оруулсан.

Хүснэгт 4. 2022 оны ХХОАТ-ын тухай хуулийн шинэчлэл, цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогод ногдох албан татварын шатлал

Жилийн орлого (₮)	Татварын хэмжээ (%)
0-120 сая (сарын 0-10 сая)	10%
120-180 сая (сарын 10-15 сая)	12 сая төгрөг дээр нэмэх нь 120 сая төгрөгөөс дээш давсан орлогод 15%
180 сая төгрөгөөс дээш (сарын 15 сая төгрөгөөс дээш)	21 сая төгрөг дээр нэмэх нь 180 сая төгрөгөөс дээш давсан орлогод 20%

Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

Сарын 10 саяас дээш буюу жилийн 120 сая төгрөгийн орлоготой иргэд нийт ХХОАТ төлөгчдийн 0.5 хувийг эзэлж байна. Ингэснээр нийт иргэдийн 99.5 хувьд энэхүү өөрчлөлт нөлөөлөхгүй буюу дундаж давхаргад дарамт болохгүй. Мөн орлогоо сайн дураар тайлагнан тооцдог хэсэгт үйлчлэхгүй бөгөөд хуучин 10 хувийн аргачлалаар явна.

Үр дүн: Энэхүү өөрчлөлт нь орлогын тэгш бус байдлыг бууруулах замаар эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна. Олон улсын түршлагаас харахад бага орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулахын тулд тэднээс авах татварын хэмжээг бууруулах, хөнгөлөх зэргээр татварын ачааллыг бууруулдаг бол өндөр орлоготой иргэдээс илүү их татвар авч хоорондох орлогын ялгааг тэнцвэржүүлэх бодлогыг баримталдаг. Гэвч энэ нь тодорхой нөхцөлүүд хангагдсан тохиолдолд л зорилгодоо хүрнэ гэдгийг анхаарах хэрэгтэй. Учир нь өндөр орлоготой нэг хэсгээс илүү татвар авч бага орлоготой иргэдэд тэтгэмж, халамжийн бодлогоор хуваарилалт хийх нь хоёр бүлгийн аль алины хөдөлмөр эрхлэх, нэмэлт орлого олох сонирхлыг бууруулах, цаашлаад эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

3.2.3 Монгол Улсад хэрэгжиж буй ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татварын ерөнхий газар (ТЕГ)-аас ХХОАТ-ын зохицуулалтын үүргийг хангах мөн эдийн засгийн өндөр өсөлтийг тогтвортой хадгалах, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжиж, дундаж болон эмзэг давхаргын амьдралын доод түвшнийг (орон сууц, сурах, хөдөлмөр эрхлэлт гэх мэт) хангах, орлогын ялгаварт байдлыг багасгах зорилтын хүрээнд хувь хүний орлогын төрөл болон бараа,

үйлчилгээг татвараас хөнгөлж, чөлөөлж байна. Монгол Улсын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Нийгэм хамгааллын чиглэлээр
2. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор
3. Боловсролыг дэмжих чиглэлээр
4. Санхүүгийн зах зээлийг дэмжих чиглэлээр
5. Бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр

2023 оны байдлаар Монгол Улсад ХХОАТ-ын 21 төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт хүчин төгөлдөр үйлчилж байна (Олон улсад энэ нь 12-16 орчим байдаг). Дэлхийн банкны Төсвийн зардлын тойм судалгаанд Монгол Улсын татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тоо их байгааг дурдсан байдаг бөгөөд энэ нь татвараас зайлсхийх арга замууд болох эрсдэлтэй, мөн татварын бааз суурийг хүмьж буйг дурдсан байдаг.

Монгол Улсын ХХОАТ-ын 2022 оны тайланг 293.9 мянган иргэн ирүүлснээс 54.1 мянган иргэн буюу 18.3 хувь нь л татварын хөнгөлөлтөд хамрагдаж, 64.4 тэрбум төгрөгийн татварыг нь буцаан олгосон байна. Тухайлбал хувьдаа анх удаа орон сууц худалдан авсан болон барьсан 32.5 мянган иргэнд 55 тэрбум төгрөг, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн сургалтын төлбөр төлсөн 21.5 мянган иргэнд 9.2 тэрбум төгрөгийн татварын буцаан олголтыг тус тус олгосон байна.

Үүнээс төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн сургалтын төлбөр төлсөн 21.5 мянган иргэнд 9.2 тэрбум төгрөгийн татварын буцаан олголтыг хэр үр ашигтай бөгөөд хүртээмжтэй олгосныг энгийн тооцоолол хийж харцгаая.

2022 оны байдлаар 145.2 мянган суралцагч их, дээд сургууль, коллежид суралцдаг ба үүнээс 21.5 мянган суралцагч л сургалтын төлбөрийн татварын буцаалт авах хүсэлт гаргасан нь 14.8 хувь байна. Тэдгээрийн дундаж сургалтын төлбөр 4.2⁷ сая төгрөг, бүх суралцагчид татварын буцаалт хүлээн авах хүсэлт гаргасан гэж үзвэл нийт 600 гаруй тэрбум төгрөгийн буцаан олголт шилжүүлэх шаардлагатай болно. Энэ нь 2022 онд олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн буцаалтаас ойролцоогоор 10 дахин их байна.

Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь хүн амын нийгмийн асуудлыг зохицуулахаас гадна татвараа үнэнч шударгаар өөрөө тодорхойлон төлөх байдлыг урамшуулж байх шаардлагатай. Гэвч дээрх тоон мэдээллээс үзэхэд Монгол Улсын хувьд ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт олон улстай харьцуулахад олон боловч нийгмийн болон зохицуулалтын үүрэг зарим талаар биелдэггүй, тодорхой бүлгийн хүмүүст тайлангаа

⁷ 2022 онд нийт татварын буцаан олголтын хэмжээ 9.2 тэрбум төгрөг байсан. Энэ нь тухайн жилд 92 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийг нийт 21,452 суралцагч төлсөн гэсэн үг юм. Үүнээс нэг суралцагчид ногдох сургалтын төлбөрийг тооцвол 4,2 сая төгрөг байна. Мөн 21,452 суралцагч нь эх олонлог болох 145 мянган суралцагчдыг төлөөлөх чадамжтай тул 4.2 сая төгрөгийг сургалтын төлбөрийн дундаж төлбөрөөр авч үзэн тооцоололд ашиглав.

өөрөө мэдүүлэх хангалттай хөшүүрэг болж чадахгүй байна гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Доорх хүснэгтэд 2020 онд ХХОАТ-аас хөнгөлөлт эдэлсэн орлогын мэдээллийг нэгтгэн харуулав.

Хүснэгт 5. ХХОАТ-аас хөнгөлөлт эдэлсэн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2020 он

ХХОАТ-аас хөнгөлөлт эдэлсэн орлогын мэдээлэл	Татвар төлөгчийн тоо	Мөнгөн дүн
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулах албан татварын хөнгөлөлт	675,134	121,799.9
Донорын олговор, Даатгалын нөхөн төлбөр, Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагналын орлогод ногдох татварын хөнгөлөлт	145	7,281.8
Үр тариа, төмс, хүнсний ногоо, түүний үр, жимс жимсгэнэ, түүний үр, суулгац гэх мэт тэжээлийн ургамал, модны суулгац үйлдвэрлэсэн болон тариалсан аж ахуй нэгжийн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	59	61.3
Өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксожсон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан бол баримтаар нотлогдож байгаа төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	17	111.8
Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад зориулж өгсөн баримтаар нотлогдож байгаа хандивтай тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	7	104.6
Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	103	8,771.9
Монгол Улсын иргэн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол ийнхүү орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авахад зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	11,703	14,706.7
Татвар төлөгчийн төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэд оюутан, эсхүл суралцагчаар элсэн суралцаж байгаа тохиолдолд түүний анхны бакалаврын болон дипломын мэргэжил эзэмших сургалтын хугацаанд тухайн татварын жилд төлсөн, баримтаар нотлогдож байгаа сургалтын төлбөртэй тэнцэх орлогод ногдох албан татварын хөнгөлөлт	11,665	6,906.0

Эх сурвалж: ТЕГ-ын үйл ажиллагааны тайлан, 2020 он

Хүснэгт 6. ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын мэдээлэл (сая төгрөг), 2020 он

ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын мэдээлэл	Татвар төлөгчийн тоо	Мөнгөн дүн
1 Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж.	366	5,094.1
2 Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого	297	12,226.9
3 Малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлого	19	306.9
4 Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг (бонд)-ийн төлбөр, хүү, анз	20	27.4
5 Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого	14	4,705.4
6 ХХОАТ-ын тухай хуулийн 16.1.12-т заасны дагуу “хувь хүн өөрийн орлого болон банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого. (2019 оны 12-р сарын 31-ны өдрөөс өмнөх)	17,074	10,938.6

Эх сурвалж: ТЕГ-ын үйл ажиллагааны тайлан, 2020 он

3.2.4 Монгол Улсын ХХОАТ-т нөлөөлөх хүчин зүйлс

ХХОАТ-ын тухай хууль, түүний хэрэгжилтэд нөлөөлөгч Монгол Улсын онцлог шинж чанар болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг Хүснэгт 7-д тусгав. ХХОАТ-ын хэрэгжилтэд нөлөөлж буй Монгол Улсын онцлог шинж чанарыг тодорхойлсноор, тэдгээр асуудалд тохирсон шийдлийг олох боломжийг олгоно.

Хүснэгт 7. Монгол Улсын ХХОАТ-т нөлөөлөх онцлог шинж чанар, хүчин зүйлсийн нэгтгэл

Хүчин зүйлс	Нөхцөл байдал	ХХОАТ-т үзүүлэх нөлөөлөл
Эдийн засгийн өсөлт	Монголбанкны мэдээлж буйгаар эдийн засгийн өсөлт 2023 онд 4.2 хувь, 2024 онд 5.2 хувь, 2025 онд 5.0 хувьд хүрнэ хэмээн таамаглаж байна.	Эдийн засаг өсөх тусам төсөвт цугларах ХХОАТ өсөх бөгөөд эдийн засгийн өсөлт нь хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг бууруулах эсвэл татвараас чөлөөлөх боломжийг бий болгож байдаг.

Эдийн засгийн бүтэц	Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагаанд Уул уурхай, олборлолт (25.1 хувь), хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, ан агнуур (13.1 хувь) болон бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ (16.1 хувь)-ний салбар давамгайлж байна.	Монгол Улс нь нөөцийн орлогоос хамааралтай учир дэлхийн зах зээлд түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан эдийн засгийн өсөлтийг бий болгож байдаг. Иймд дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ өсөх нь ХХОАТ-ын хэмжээ өсөх нөхцөлийг бүрдүүлж байдаг.
Инфляц	2023 оны долдугаар сарын байдлаар улсын инфляцын түвшин 9.2 хувь байна.	Инфляцын түвшин өндөр байх нь иргэдийн худалдан авах чадварыг бууруулж, татварын дарамт үүсгэх боломжтой тул Засгийн газраас албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхэд хүргэж болзошгүй байдаг.
Улс төр	1992 оноос хойш Монгол Улсын Сангийн яам нь нийт 15 удаагийн томилгоогоор 13 сайдтай байсан. Тус хугацаан дахь Сангийн яамны сайдын тус албан тушаалыг хашсан дундаж хугацаа нь 2.07 жил байна.	Улс төрийн тогтвортой байдал нь улс орны бодлого зохицуулалт, хөгжил дэвшилд чухал нөлөөтэй хэдий ч Монгол Улсын хувьд улс төрийн тогтвортой байдал төдийлөн сайн хангагдаагүй байгаа нь ХХОАТ бодлого зохицуулалтын хэрэгжилт, хяналт, шинэчлэлд сөрөг нөлөө үзүүлж байх магадлалтай.
Хотжилт	Монгол Улсад хотжилт хурдацтай явагдаж байгаа бөгөөд 2022 оны байдлаар хүн амын 48.9 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна.	Хот суурин газрын орлогын түвшин өсөх нь ХХОАТ ногдуулах орлогыг нэмэгдүүлэх боломжтой юм. Учир нь хот суурин газрын татвар төлөх, тайлагнах чадавх хөдөө орон нутгаас илүү өндөр байдаг.
Хөдөлмөр эрхлэлт	Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 1992 оноос 2022 он хүртэл 23 хувиар буурсан байна.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурах нь эдийн засаг, улс орны хөгжил дэвшил болон ХХОАТ-ын хэрэгжилт сөрөг нөлөөтэй. Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ авах шаардлагатай байна.
Санхүүгийн мэдлэгийн түвшин	Монгол Улсын иргэдийн санхүүгийн боловсролын чадамжийн түвшин 49.5 хувь. Энэ нь Төв Азийн орнуудын санхүүгийн боловсролын дундаж 56.5 хувиас 7 хувиар бага үзүүлэлт болж байна. ⁸	Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин бага байх нь ХХОАТ төлөх, тайлагнах түвшин болон татварт хандах хандлагад сөргөөр нөлөөлөх боломжтой.
Хууль дээдлэх ёсны индекс	0.54	2015 оноос хойш Монгол Улсын хууль дээдлэх ёсны индекс дунджаар 0.54-аас огцом өөрчлөгдөөгүй байгаа нь иргэдийн дундах хууль (Үүнд: ХХОАТ-ын тухай хууль багтана) даган мөрдөх сэтгэхүй, хандлага илт сайжрахгүй байгааг илтгэж байна.

Эх сурвалж: YCX (2022 он), Монголбанк (2022, 2023 он), Worlddata.info (2022 он), World Justice Project (2022 он)

⁸ Монголбанк, “Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа”, УБ., 2022 он.

IV. Монгол Улсад ХХОАТ ногдуулж буй орлогын эх үүсвэрийн шинжилгээ

4.1 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын танилцуулга, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд

ХХОАТ-ын цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогуудын мэдээллийг нарийвчлан тодорхойлж дэлгэрэнгүйг Хүснэгт 8-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 8. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл

№	Татвар ногдуулах орлого	Хасагдах зардал	Хувь хэмжээ	Хугацаа		Татвар төлөгч
				Ногдуулан төлөх	Тайлагнах	
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого						
1	Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн нэмэгдэл амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж тэдгээртэй адилтгах бусад орлого	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасаж тооцно.	10 хувь	Сар бүрийн эцэст ногдуулж, хөнгөлөлтийг хасна. Дараа сарын 10-ны дотор төсөвт шилжүүлнэ.	Орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулна, дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор	Суутгагч
2	Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого					
3	Ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг					
4	Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого					
5	Гадаад дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого					
6	Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого					
7	Хоол, унааны мөнгө					

Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль


Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод хамаарах эх үүсвэрүүдийн (1) татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох нь тодорхой (2) тогтоосон орлогод ногдуулах хувь хэмжээ тодорхой, (3) тухайн орлогыг хэн, хэдий хугацаанд ногдуулан төсөвт төлөх, тайлагнах нь тодорхой байна.

2023 оноос эхлэн Монгол Улс шаталсан татварын хувь хэмжээг тооцож эхэлсэн. Энэ нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг суутган хэлбэрээр төлж буй иргэдэд хамааралтай байна. Өмнөх бүлэгт дурдсаны дагуу татвар нь үндсэн 3 үүрэгтэй ба тэдгээр нь ХХОАТ-ын эх үүсвэрүүдийн хувьд хэрхэн хэрэгжиж буйг санхүүгийн буюу төсвийн болон зохицуулалтын үүргүүдийнх нь хувьд авч үзэв.

Санхүүгийн буюу төсвийн үүрэг: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого нь сүүлийн 5 жилд дунджаар нийт улсын төсөвт ХХОАТ-ын төвлөрүүлсэн дүнгийн 75 хувийг бүрдүүлж байна. 2020 онд цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын татвар нь 69.9 хувийг бүрдүүлж байсан бол түүнээс хойш тасралтгүй өссөн байгаа нь энэхүү эх үүсвэрийн санхүүгийн буюу төсвийн үүргийн хэрэгжилт илүү нэмэгдэж байна гэж харж болохоор байна. Манай улс ХХОАТ-ыг ажиллаж буй хүмүүсээс суутган авах, иргэд өөрсдөө мэдүүлэх замаар сайн дураар төлөх гэсэн хоёр тусдаа хэлбэрээр тооцдог.

2020 оны байдлаар цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлого ологсдоос сайн дураар татварын тайлангаа илгээсэн 132 мянган иргэн байгаа ба энэ нь тайлан тушаавал зохих иргэдийн 68 хувь юм.

График 8. ХХОАТ-ын дүнд эзлэх цалин, түүнтэй адилтгах орлого (2019-2023 он)



Эх сурвалж: Төсвийн тодотгол, 2023 он⁹

Мөн 2023 оноос эхлэн хэрэгжсэн шаталсан татварын тогтолцоо нь жилийн 120 сая төгрөгийн орлоготой иргэдэд нөлөө үзүүлэхээр буй ба нийт ХХОАТ төлөгч 816 мянган хүний 0.5 хувь нь буюу 1300 иргэн л хамрагдана гэсэн тооцоо судалгааг Сангийн яамнаас гаргасан байна. Энэхүү шинэчлэлт нь цөөн хүнд хамаарах хэдий ч татварын төсөвлөсөн дүнд эерэг нөлөөг үзүүлнэ хэмээн харж байна.

⁹ 2023* - 2023 оны төсөвт тодотгосон дүн

Эдгээрээс дүгнэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого нь санхүүгийн буюу төсвийн үүргээ хангалттай биелүүлж байна гэж дүгнэж байна.

Зохицуулалтын үүрэг: Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулан олон төрлийн бодлого арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой ба цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос дараах орлогуудыг ХХОАТ-аас чөлөөлөх болон хөнгөлж байна.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн дараах орлогыг ХХОАТ-аас чөлөөлнө.

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;
- ✓ Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж;
- ✓ Гамшгийн үед олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газар, хуулийн этгээд, иргэнээс Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үзүүлж байгаа тусламж;
- ✓ Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллагад томилогдон ажиллаж байгаа дипломат ажилчин, түүний гэр бүлийн гишүүдийн цалингийн орлого, нэмэгдэл;
- ✓ Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллагад томилогдон ажиллаж байгаа дипломат ажилчин, түүний гэр бүлийн гишүүдийн гадаад улсад олсон орлого.

Мөн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах байдлаар ХХОАТ-ын хөнгөлөлт үзүүлнэ.

Хүснэгт 9. Монгол Улсын ХХОАТ-ын тухай хуульд заасан цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод үзүүлэх хөнгөлөлт

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ (төгрөг)	Хөнгөлөлтийн хэмжээ (төгрөг)
0 - 6,000,000 хүртэл	240,000
6,000,000 - 12,000,000 хүртэл	216,000
12,000,000 - 18,000,000 хүртэл	192,000
18,000,000 - 24,000,000 хүртэл	168,000
24,000,000 - 30,000,000 хүртэл	144,000
30,000,000 - 36,000,000 хүртэл	120,000
36,000,000 ба түүнээс дээш	-

Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

2020 оны байдлаар нийт 18 мянга гаруй хүний 33 тэрбум төгрөгийн татвар ногдох орлогыг ХХОАТ-аас чөлөөлж, 727.5 мянган хүний 159.7 тэрбум төгрөгийн татвар ногдох орлогод ХХОАТ-ын хөнгөлөлтийг олгосон байна.

Үүнийг төрлөөр нь ангилан харвал цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох татварын хөнгөлөлт нь нийт хөнгөлөлтийн 76 хувийг бүрдүүлж байгаа бол татварын хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн бүцэлтгүй тусламж, хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогын чөлөөлөлт нь нийт ХХОАТ-аас чөлөөлөгдсөн орлогын 52 хувийг бүрдүүлж байна.

ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнд эзлэх цалин, хөдөлмөрийн хөлсний орлогын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ өндөр байгаа нь эх үүсвэрийн дүн өндөр байгаатай холбоотой бөгөөд энэ нь тухайн татварын зохицуулалтын үүрэг хангагдаж байна гэсэн үг биш юм.

Япон Улсын хувьд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь гэр бүл, ялангуяа хэн нэгнийг асран хамгаалдаг айл өрхөд санхүүгийн хөнгөлөлт үзүүлж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, өндөр настнаа асрахтай холбоотой санхүүгийн ачааллыг бууруулахад тусалдаг. Тухайн хүний гэр бүлийн нөхцөл байдал, онцгой шаардлага зэргийг харгалзан үзэж татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгох нь сайн дураар татвар төлөгчдөд хөшүүрэг болдгоос гадна татварын зохицуулах үүрэг зохих ёсоор хангагдаж, зорилтот бүлгээ дэмждэг байна. Мөн тус улсад хөдөлмөрийн бүтээмж, мэдлэг ур чадвар, илүү цагаар хөдөлмөрлөх гэх мэт хүчин зүйлсийг хамруулан авч үзсэн тодорхой хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтыг хийсэн байдаг нь ажил эрхлэгчид өөрийн ХХОАТ-ын тайлангаа үнэн, зөв нээлттэй гаргахад эерэг нөлөө үзүүлдэг байна.

Цалин, хөдөлмөрийн хөлсний орлогын эх үүсвэрт хамруулж буй хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг дээрх олон улсын сайн туршлагатай харьцуулан харвал бодлогын чиглэл хангалттай тодорхой биш, урт хугацааны зорилтод нийцсэн зохицуулалт багатай, хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн онцлог, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, нөөц бололцоог тооцоогүй гэх мэт олон улсад хэрэгждэг олон бодлого, зохицуулалт дутуу байна гэж тодорхойлж болохоор байна.

Монгол Улсын ХХОАТ дахь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дүн шинжилгээ хийж үзэхэд дараах асуудлууд байна гэж харж байна. Үүнд:

- ✓ Татварын бааз суурь хангалтгүй;
- ✓ Ам бүлийн гишүүдийн тоо болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг тооцоогүй буюу өрхийн ам бүлийн тоо, ажил эрхэлж буй өрхийн гишүүний тоо, тэжээлгэгч иргэдийн тоо зэргийг харгалздаггүй;

- ✓ Хөдөлмөрийн бүтээмж, мэдлэг, үр чадвар, илүү цагаар хөдөлмөрлөх гэх мэт хүчин зүйлсийг хамруулан авч үзэх зохицуулалт байхгүй;
- ✓ Татварын албаны мэдээллийн баазын чанар дутмаг;
- ✓ Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого нь оновчтой биш, хэрэгжилт хангалтгүй;
- ✓ Хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой зохицуулалтын хэмжээ олон улстай харьцуулахад олон боловч томъёолол нь харьцангуй нарийвчилж зохицуулж чадаагүй, тодорхой бус, оновчгүй байна.

4.2 Үйл ажиллагааны орлогын танилцуулга, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд

ХХОАТ-ын үйл ажиллагааны орлого дахь нарийвчлан тодорхойлсон орлогын эх үүсвэрүүдийн мэдээлэл, хувь хэмжээ, тайлагналын тухай дэлгэрэнгүйг Хүснэгт 10-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 10. Үйл ажиллагааны орлого, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл

№	Татвар ногдуулах орлого	Хасагдах зардал	Хувь хэмжээ	Хугацаа		Татвар төлөгч
				Ногдуулах төлөх	Тайлагнах	
Үйл ажиллагааны орлого						
1	Бие даан эрхэлсэн мэргэжлийн үйлчилгээний орлого	Доор дурдсан нөхцөл, шаардлагыг хангасан зардлуудыг хасаж тооцно.	10 хувь	Улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор	ХХОАТ тодорхойлох тайлангийн хуудсаар гаргаж, дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор	Жилийн эцэст татвар төлөгч өөрөө тооцоо хийнэ
2	Хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зүүчлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого					
3	Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого					
4	Эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээ					
5	Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлого					

Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

Татвар ногдох орлогоос хасагдах зардлууд


Үйл ажиллагааны орлогод албан татварын ногдуулах орлогыг тодорхойлохдоо доорх шаардлагыг хангасан зардлыг хасаж тооцно. Үүнд:

- ✓ Үйл ажиллагааны орлогод албан татварын ногдуулах орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1-д заасан шаардлагыг хангасан зардлыг хасаж, мөн хуулийн 13.2-т заасан зарчмыг баримталж, 14, 15, 16, 17 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.
- ✓ ХХОАТ хуулийн 15.1-д заасан хасагдах зардлыг албан татвар төлөгч хувийн хэрэглээндээ зарцуулсан бол албан татвар ногдох орлогоос хасахгүй.
- ✓ Албан татвар төлөгч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал түүнд ногдох үйл ажиллагааны зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохгүй.
- ✓ Албан татвар төлөгч үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж байгаа машин, механизм, тоног төхөөрөмж, барилгыг гэр бүлийнхээ хэрэгцээнд нэгэн зэрэг ашиглаж байгаа бол ашиглалтын зардлыг хувь тэнцүүлэн тооцож, албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тусгана.
- ✓ Албан татвар төлөгчийн гэр бүлийн гишүүнд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно.
- ✓ Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн хувь хүн өөрөө хүсэлт гаргаж, уг хүсэлтийг харьяа татварын алба бүртгэж авсан бол түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

Үйл ажиллагааны орлогод хамаарах эх үүсвэрүүдийн (1) татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох нь нарийвчилсан зохицуулалтгүй, ерөнхий, (2) тогтоосон орлогод ногдуулах хувь хэмжээ тодорхой, (3) хөрөнгийн орлогыг хэн, хэдий хугацаанд ногдуулан төсөвт төлөх, тайлагнах нь тодорхой байна.

Санхүүгийн буюу төсвийн үүрэг: Үйл ажиллагааны орлого нь иргэд өөрсдөө татварын албанд тайлагнадаг төрлийн орлого юм. Энэхүү орлогод ногдох татвар нь сүүлийн 5 жилд дунджаар нийт улсын төсөвт ХХОАТ-ын төвлөрүүлсэн дүнгийн 4.7 хувийг бүрдүүлж байна.

График 9. ХХОАТ-ын дүнд эзлэх үйл ажиллагааны орлого (2019-2023 он)



Эх сурвалж: Төсвийн тодотгол, 2023 он¹⁰

2022 оны гүйцэтгэлээр 52.5 тэрбум төгрөг үйл ажиллагааны орлогын татвараас төсөвт цугласан байна. Үйл ажиллагааны орлогын 4 эх үүсвэрийг манай улсын хувьд тодорхойлсон байдаг ба ХХОАТ-ын сайн жишиг болсон улсуудтай харьцуулахад цөөн бөгөөд ерөнхий агуулга бүхий өргөн цар хүрээг хамарсан байна.

Тодруулбал, Монгол Улсын эдийн засагт нөлөө бүхий үйл ажиллагааны салбарт ажиллаж буй бөөний, жижиглэн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааны орлого, малчдын мал, малын түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүнээс олсон орлого зэрэг нь албан татварт хамрагдах боловч яг хэрхэн тооцох, тодорхойлох талаар мэдээлэл хангалтгүй, тэдгээрийг татварын тайлан илгээхийг уриалсан, мэдээллээр хангасан байдал дутмаг байна.

Эдгээрээс дүгнэхэд ХХОАТ дахь үйл ажиллагааны орлогын албан татвар нь төсвийн үүргээ хангалттай сайн биелүүлж чадахгүй байгаа ба үүний шалтгаан нь үйл ажиллагаанаас тооцох татварын нэр төрөл, тодорхойлолт тодорхой бус, ерөнхий байна. Үүний улмаас татвар төлөгчдийн дунд төөрөгдөл үүсэх, зарим тохиолдолд татвараас зайлсхийх боломжийг бий болгох, ойлголтын зөрүүтэй байх, татварын мэдлэг, мэдээлэл дутмаг байдлаас үүдэн татварын тайлагналаа илгээхгүй байх зэрэг асуудлууд бий болох үр дагавартай байна.

Зохицуулалтын үүрэг: ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулан олон төрлийн бодлогыг хэрэгжүүлэх боломжтой ба үйл ажиллагааны орлоготой холбоотой дараах ХХОАТ-ын хөнгөлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Дараах бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн болон тариалсан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө. Үүнд үр тариа; төмс, хүнсний ногоо, түүний үр; жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац; тэжээлийн ургамал; модны суулгац.

¹⁰ 2023* - 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

- ✓ Аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн ХХОАТ-ын хуулийн 6.3.2-т заасан орлогод ногдох албан татварыг аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлнө.

2020 оны байдлаар нийт ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнд дээрх орлогуудын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 5.5 хувийг л эзэлж байна. Өөрөөр хэлбэл энэ төрлийн орлогын төсөвт төвлөрсөн дүн хангалтгүй, мөн энэ төрлийн орлогод үзүүлж буй хөнгөлөлт, чөлөөлөлт цөөхөн байгаа ба зорилтот бүлгээ дэмжээгүй, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцээгүй гэж харж болно.

Олон улсын сайн жишиг болсон улсуудын туршлагаас харахад татварын тогтолцоо нь татварыг үр ашигтай цуглуулах, удирдахад гол анхаарал хандуулдаг ба татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалсан, нийгэмд чиглэсэн бодлогыг ихээр хэрэгжүүлдэг байна. Манай улсын хувьд хувиараа аж ахуй эрхлэгч нарыг дэмжих таатай орчин нөхцөл, бодлого, зохицуулалт хангалтгүй, мөн тэдгээрийн үйл ажиллагаанаас төлөх татварт оновчтой хөнгөлөлт, чөлөөлөлт байхгүй байгаа нь тэдгээрийн хөгжилд саад учруулж байна.

“ХХОАТ-ын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилт, анхаарах асуудлууд” судалгааны ажилд хувиараа бизнес эрхлэгч болон ХХОАТ-ын хуульд заасны дагуу үйл ажиллагааны орлого олж, түүнээс татвар төлж буй иргэдээс судалгаа авсан ба тус судалгааны үр дүнг харахад судалгаанд оролцогчдын 29 хувь нь татвар төлөх иргэний үүргээ биелүүлэх, 48 хувь нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, үлдсэн 23 хувь нь бусад зорилгоор татварын тайлангаа илгээдэг гэсэн байна.¹¹

Татварын албанаас авсан өөр нэгэн судалгаанаас үзвэл тус судалгаанд хамрагдсан иргэдийн 75 хувь нь тайлан гаргаж татварын тооцоо хийх хүндрэлтэй гэж хариулсан байгаа нь иргэдийн татварын боловсрол тааруу бөгөөд татварын мэргэшсэн зөвлөхийн туслалцаа шаардлагатай байгааг харуулж байна. Мөн нөгөө талаар хувиараа бизнес эрхлэгч иргэдийн орлого буюу үйл ажиллагааны орлого, татварыг тодорхойлох, тайлагнах процесс нь аж ахуйн нэгжтэй адил нарийн төвөгтэй байгаа нь татвараа тайлагнахад төвөг учруулж байна хэмээн дүгнэжээ.

Орчин үед хувь хүний орлогын эх үүсвэрүүдийн төрөл өргөжин тэлж байгаа ба үүн дотроо цахимаар олж буй орлогын төрлүүд нэмэгдэж байна. Үүнд:

1. Цахим худалдаанаас олсон орлого (бараа бүтээгдэхүүн борлуулж буй цахим хаяг)
2. Цахим сургалтаас олж буй орлого
3. Контент бүтээгчдийн орлого (цахим хаягаас олж буй орлого, зар сурталчилгаанаас олсон орлого) гэх мэт.

¹¹ М.Энхсүрэн, ХХОАТ-ын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилт, анхаарах асуудлууд, УБ., 2016.

Үйл ажиллагааны орлогын төрөлд эдгээр орлогын эзлэх хувь нэмэгдэж байгаа хэдий ч тэдгээрийг бодит тоо баримтаар нотлох тооцоолол, судалгаа одоог хүртэл албан ёсоор хийгдээгүй байна. Иргэдийн дунд мөн эдгээр орлогын эх үүсвэрээс татвар төлөх тухай ойлголт хангалтгүй байгаа ба үүнийг нийт ХХОАТ-ын дүнд үйл ажиллагааны орлогоос орж ирж буй татварын орлогын дүн сүүлийн 5 жилд өсөөгүй байгаагаас харж болно.

Манай улсын татварын хуульд татвар ногдох орлогыг ерөнхий агуулгаар нь тусгаж, орлогын төрлийг хэт нарийн зааснаар хуульд тусгаагүй, ирээдүйд үүсэж болох шинэ төрлийн орлогод татвар ногдохгүй байх эрсдэлтэй. Гэвч өмнө тодорхойлсон орлогын эх үүсвэрүүдээсээ хангалттай хэмжээний татвар хурааж чадахгүй байгаа нь орлогын эх үүсвэрүүдийг хэт ерөнхий тодорхойлсонтой холбоотой байж болно. Тиймээс Монгол Улсын хувьд ХХОАТ-ын тухай хуульд орлогын төрлийг нарийвчлан оруулахаас илүүтэйгээр тухайн орлогыг татваржуулах хяналтын системийг хэрхэн бүрдүүлэх тал дээр илүү анхаарал хандуулж, сайн туршлага судлах нь зүйтэй байна.

Дээрхээс дүгнэхэд ХХОАТ дахь үйл ажиллагааны орлогын албан татвар нь санхүүгийн болон зохицуулалтын үүргүүдийг тодорхой түвшинд биелүүлж байгаа боловч олон улстай харьцуулахад хэрэгжилтийн түвшин хангалтгүй, зохицуулалт тодорхой бус, тайлагнахад хүндрэлтэй мөн түүнийг бүрдүүлэгч татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалсан, нийгэмд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх тал дээр хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын ХХОАТ дахь үйл ажиллагааны орлогод дүн шинжилгээ хийж үзэхэд дараах асуудлууд байх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- ✓ Үйл ажиллагааны орлогыг тодорхойлсон тодорхойлолт, нэр томьёо нь хэт өргөн цар хүрээг хамарсан ерөнхий бөгөөд тодорхой бус;
- ✓ Технологийн дэвшлийн улмаас өмнө байгаагүй, шинээр бий болсон орлогод хэрхэн татвар ногдуулах арга зүй байхгүй;
- ✓ Хувиараа бараа бүтээгдэхүүн борлуулах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх бизнесийн орлого буюу үйл ажиллагааны орлогод татвар ногдуулах үйл явц, хэрэгжилт хангалтгүй;
- ✓ Үйл ажиллагаа эрхэлдэг иргэд бүртгэлээ хэрхэн хөтөлж орлого, зардал, татвараа тодорхойлох нь тодорхойгүй, тэдгээр нь хангалттай мэдлэг, мэдээлэлгүй;
- ✓ Татвартөлдөггүй, тайлагнадаггүй иргэдийн олсон орлого буюу татварт хамруулж чадахгүй байгаа орлогоос татвар хураахад чиглэсэн бодлого хангалтгүй;
- ✓ Татвар төлөлтийг нэмэгдүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын хэрэгжилт хангалтгүй, зорилтот иргэддээ зориулсан зохицуулалт бага;
- ✓ Татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалсан, нийгэмд чиглэсэн бодлого хэрэгжүүлэлт хангалтгүй;

- ✓ ХХОАТ тайлан илгээх үйл явц нь суутган төлөгчийн орлогод ногдох албан татварыг тайлагнахад илүү хялбар хэдий ч үйл ажиллагаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгө (ҮХХ) түрээслүүлэгч болон бусад орлогыг тайлагнах үйл явц илүү хүндрэлтэй, иргэдэд ойлгомжгүй байх тал ажиглагдаж байна.
- ✓ Ам бүлийн гишүүдийн тоо болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг тооцоогүй буюу өрхийн ам бүлийн тоо, ажил эрхэлж буй өрхийн гишүүний тоо, тэжээлгэгч иргэдийн тоо зэргийг харгалзан авч үзсэн зохицуулалт байхгүй.

ХХОАТ-ын хөнгөлөлт, зохицуулалт цөөн байдаг нь тэдгээрээр дамжин хэрэгжих бодлого хангалтгүй байдагтай холбоотой гэж нэг талаар үзэж болно. Өөрөөр хэлбэл нийгмийн болон эдийн засгийн тодорхой салбаруудыг дэмжих бодлого зохицуулалт хангалтгүй хэмжээнд байна.

4.3 Хөрөнгийн орлогын танилцуулга, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд

ХХОАТ-ын үйл ажиллагааны орлого дахь нарийвчлан тодорхойлсон орлогын эх үүсвэрүүдийн мэдээлэл, хувь хэмжээ, тайлагналын тухай дэлгэрэнгүйг хүснэгт 11-т нэгтгэн харуулав.

Хүснэгт 11. Хөрөнгийн орлого, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл

№	Татвар ногдуулах орлого	Хасагдах зардал	Хувь хэмжээ	Хугацаа		Татвар төлөгч (өөрөө суутгагч)
				Ногдуулах төлөх	Тайлагнах	
Хөрөнгийн орлого						
1	Түрээсийн орлого	Хөрөнгө ашиглуулсны, эсхүл түрээслүүлсний нийт орлогоос тухайн хөрөнгийг ашиглуулах, эсхүл түрээслүүлэхтэй холбогдон гарсан баримтаар нотлогдох зардал	10 хувь	Дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор	ХХОАТ тодорхойлох тайлангийн хуудсаар гаргаж, дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор	Жилийн эцэст татвар төлөгч өөрөө тооцоо хийнэ
2	Эрхийн шимтгэлийн орлого				Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор	
3	Ногдол ашгийн орлого					
4	Хүүгийн орлого ¹²					


Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

¹² Түрээсийн орлогод хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө түрээслүүлсний орлого хамаарна. Ногдол ашгийн орлогод хувь нийлүүлсэн хуулийн этгээдээс ашиг хуваах, хувь хүртээх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого, түүний хүү хамаарна. Хүүгийн орлогод зээлийн хүү, харилцах дансны үлдэгдэл, мөнгөн хадгаламжийн хүү, батлан даалт гаргасны төлбөр, өрийн бичиг (бонд), хууль болон гэрээний дагуу авч байгаа хүү, анз хамаарна.

Хөрөнгийн орлогод хамаарах эх үүсвэрүүдийн (1) татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох нь тодорхой, (2) тогтоосон орлогод ногдуулах хувь хэмжээ тодорхой, (3) хөрөнгийн орлогыг хэн, хэдий хугацаанд ногдуулан, төсөвт төлөх, тайлагнах нь тодорхой байна.

Санхүүгийн буюу төсвийн үүрэг: Хөрөнгийн орлого нь иргэд өөрсдөө татварын албанд тайлагнадаг төрлийн орлого бөгөөд сүүлийн 5 жилд энэхүү орлого нь дунджаар нийт улсын төсөвт төвлөрүүлсэн ХХОАТ-ын дүнгийн 10.4 хувийг бүрдүүлж байна.

График 10. ХХОАТ-ын дүнд эзлэх хөрөнгийн орлого (2019-2023 он)



Эх сурвалж: Төсвийн тодотгол, 2023 он

Хөрөнгийн албан татварыг төрлөөр нь задлан харвал үл хөдлөх хөрөнгийн татвар 67.4 хувийг, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 24.3 хувийг, малд ногдуулах татвар 7.7 хувийг, бууны татвар 0.5 хувийг тус тус бүрдүүлж байна. Гэвч тодорхой хувийг бүрдүүлж буй үл хөдлөх хөрөнгийн түрээстэй холбоотой мэдээлэл хангалтгүй байгаа нь энэ төрлийн орлогод ногдох татварын дүнг тооцоолох боломжгүй нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

Орон сууцнаас гадна хашаа байшин, машин механизм гэх мэт олон төрлийн хөрөнгийг бусдад ашиглуулах замаар орлого олж байгаа иргэдийг татварт хамруулж чадаж буй эсэх талаар мэдээлэл дутмаг байгаа ба хэрэв эдгээртэй холбоотой статистик, тооцоолол, судалгаа нэмэгдвэл тэдгээрийг судлахад илүү ач холбогдолтой болох юм.

Европ, Америк, Скандинавын орнуудад газар, үл хөдлөхийн бүртгэлийн системийг маш тодорхой хийж өгсөн байдаг ба тухайн системээр дамжуулан татвар хураах сууриа тооцоолдог байна. Манай улсын хувьд ч мөн бүртгэл, мэдээлэл, хяналтын нэгдсэн системийг бий болгох, тэдгээрийг сайжруулах нэн шаардлагатай байна.

Зохицуулалтын үүрэг: Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулан олон төрлийн бодлогыг хэрэгжүүлэх боломжтой ба хөрөнгийн орлоготой холбоотой дараах татварын хөнгөлөлт манай улсад байна. Үүнд:

- ✓ Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичиг (бонд)-ийн төлбөр, хүү, анз

ТЕГ-аас “Мөнгөний болон санхүү, татварын харилцан уялдаатай бодлогоор хуримтлалыг бий болгон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувьцааны ногдол ашиг, хүүгийн орлого, санхүү даатгалын үйл ажиллагаанд оролцогчдыг дэмжих” зорилтын хүрээнд энэхүү хөнгөлөлтийг тодорхойлсон байна.

Дээрх хөнгөлөлтийн хүрээнд 2020 онд нийт 20 хүнд 27.4 тэрбум төгрөгийг олгосон байна. Энэ нийт хөнгөлөлт, чөлөөлөлтийн 0.01 хувийг эзэлж байна. Олон улсын жишигт иргэдийн санхүүгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, нийт хуримтлалыг тогтворжуулах зорилгоор хадгаламж, ногдол ашгаас олох татварыг хөнгөлдөг байна.¹³

Монгол Улсын ХХОАТ дахь хөрөнгийн орлогод дүн шинжилгээ хийж үзэхэд дараах асуудлууд байна гэж үзэж байна. Үүнд:

- ✓ ҮХХ түрээсийн бизнесийн нийт орлогыг тооцох, түүнийг хянах арга зүй, систем хангалтгүй;
- ✓ Татварын албаны мэдээллийн баазын чанар дутмаг;
- ✓ Татвар үл төлдөг, тайлагнадаггүй иргэд, татварт хамруулж чадахгүй байгаа орлогоос татвар хураахад чиглэсэн бодлого хангалтгүй;
- ✓ ХХОАТ-ын тайланг илгээх, төсөвт шилжүүлэх үйл явцыг бүрэн хялбаршуулж системжүүлээгүй.

4.4 Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын татварын зохицуулалт, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд

ХХОАТ-ын тухай хуульд зааснаар албан татвар ногдуулж буй хөрөнгийн борлуулсан, шилжүүлсний орлогод багтах орлогын эх үүсвэрүүд, тэдгээрт татвар ногдуулах хувь хэмжээг хэрхэн тодорхойлох, ногдуулсан албан татварыг төлөх болон тайлагнах хугацаа, мөн ногдуулан төлөх этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 12-т харуулав.

¹³ Татварын Ерөнхий Газар, Үйл ажиллагааны танилцуулга, УБ, 2020 он.

Хүснэгт 12. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдох татварын зохицуулалт

№	Татвар ногдуулах орлого	Хувь хэмжээ	Хугацаа		Татвар төлөгч (өөрөө суутгагч)
			Ногдуулах, төлөх	Тайлагнах	
Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого					
1	Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого	Оршин суугч 2 хувь, Байнгын оршин суугч биш 10 хувь (Борлуулалтын нийт дүнгээс тооцно)	1. Тухай бүр албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх 2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон ҮХХ борлуулсны орлогод албан татвар ногдуулж, дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор.	1. Орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулна, дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор; 2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч нь гадаад улсад ҮХХ борлуулсны орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.	1. Суутгагч 2. Татвар төлөгч
2	Газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого	10 хувь (Борлуулсан, шилжүүлсний орлогоос холбогдох төрийн байгууллагад төлсөн баримт, бусад холбогдох зардлыг хассан дүнгээс тооцно)	Тухай бүр албан татвар ногдуулан, дараа сарын 15-ны өдрийн дотор	Албан татварын тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ	Татвар төлөгч
3	Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого	10 хувь (Борлуулсан, шилжүүлсний орлогоос холбогдох төрийн байгууллагад төлсөн баримт, бусад холбогдох зардлыг хассан дүнгээс тооцно)			
4	Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого	10 хувь (Үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлогоос уг хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээр)			


Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод хамаарах эх үүсвэрүүдийн (1) татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох нь тодорхой, (2) тогтоосон орлогод ногдуулах хувь хэмжээ тодорхой, (3) орлогыг хэн, хэдий хугацаанд ногдуулан төсөвт төлөх, тайлагнах нь тодорхой байна.

Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогын ХХОАТ-ын санхүү, төсвийн болон зохицуулалтын үүргийн хэрэгжилтийг дараах байдлаар тодорхойлов.

Санхүү, төсвийн үүрэг: Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого нь сүүлийн 5 жилд дунджаар нийт улсын төсөвт ХХОАТ-ын төвлөрүүлсэн дүнгийн 1.18 хувийг бүрдүүлж байна. Ингэхдээ тус дүн нь 2021 онд огцом өссөн нь “Ковид-19” цар тахлаас үүдэн БНХАУ “Тэг ковид” бодлого хэрэгжүүлэн, хилийн хориг тогтоосноор Монгол Улсын барилгын өртгийн индекс 2021 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 30.2 хувиар огцом өссөн нь ҮХХ-ийн үнэд нөлөөлж, улмаар хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогыг нэмэгдүүлсэн байна.

График 11. Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулсан албан татварын хэмжээ, ХХОАТ-т эзлэх хувиар, 2016-2023 он



Эх сурвалж: Төсвийн тодотгол, 2023 он

Монгол Улсад үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого, газар эзэмших эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдох албан татварыг улсын бүртгэлийн газар нэр шилжүүлэх хүсэлт өгөхийн өмнө улсад тушаах тогтолцоо хэрэгжиж байдаг. Мөн Монгол Улсад хувьцаа болон үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсан тохиолдолд түүний өссөн дүнг брокер, дилерийн мэдээлснээр албан татвар ногдуулдаг системээр ажиллаж байна. Иймд Монгол Улс дахь хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдох албан татвараас хуульд заасны дагуу тодорхойлогдож буй төлбөл зохих иргэдийг бүрэн хамарч чадаж байгаа хэмээн үзэж байна.

Харин гадаад улсад олсон хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулах албан татварыг татвар төлөгч өөрөө тодорхойлж, тайлагнах үүрэг хүлээдэг ба түүнийг хянах тогтолцоо сул байдгаас үүдэн албан татвар төлбөл зохих иргэдийг бүрэн хамруулж чадахгүй байх магадлалтай байна. Иймд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогыг санхүү, төсвийн үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж байна хэмээн үзэхэд учир дутагдалтай байна.

Зохицуулалтын үүрэг: Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулах албан татвартай холбоотой хөнгөлөлт байхгүй бөгөөд зөвхөн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг албан татвараас чөлөөлөх хууль Монгол Улсад хэрэгжиж байна. Үүнд:

- ✓ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээд хоорондоо газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлогыг албан татвараас чөлөөлөх;

Дээр дурдсаны дагуу ХХОАТ-ын тухай хуульд зөвхөн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого гэж тусгагдсан тул, үүнд газар өмчлөх эрхийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлогыг хамруулахгүй. Мөн тус хуульд “эрхийн гэрчилгээг үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого” хэмээн дурдсан нь иргэдийн дунд тус орлогод ямар төрлийн орлогыг тооцож авч үзэх талаар эргэлзээ үүсгэхээр байна.

ХХОАТ-ын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар үл хөдлөх эд хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгийг зөвхөн борлуулсны орлогод албан татвар ногдуулж байна. Гэвч зах зээлд зөвхөн худалдах, худалдан авах гэрээ (ХХАГ)-нээс бусад тохиолдлоор хөрөнгийг шилжүүлэх боломжтой байдаг¹⁴ бөгөөд тэдгээрт татвар ногдуулахгүй байгаа нь ХХАГ-ээс бусад төрлийн гэрээ хэлцлээр үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг шилжүүлэх замаар ХХОАТ-аас зайлсхийх боломжтой байгааг илтгэж байна. Хүснэгт 13-т 2022 оны эхний хагас жилд хийгдсэн үл хөдлөх эд хөрөнгө болон газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэлийн тоо хэмжээг гэрээ хэлцлийн төрлөөр харууллаа.

Хүснэгт 13. 2022 оны эхний хагас жилд хийгдсэн үл хөдлөх эд хөрөнгө болон газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэлийн тоо хэмжээ, гэрээ хэлцлийн төрлөөр

Гэрээ хэлцлийн төрөл	Гэрээний тоо	Нийт дүнд эзлэх хувь
ХХАГ	520	72.93%
Арилжааны гэрээ	0	0%
Бэлэглэлийн гэрээ	64	8.98%
Өв залгамжлах	69	9.68%
Хамтран өмчлөгч өөрчлөх	52	7.29%
Бусад	8	1.12%
НИЙТ	713	100%

Эх сурвалж: УБЕГ (2022 он)

Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод дүн шинжилгээ хийж үзэхэд дараах асуудал, анхаарах зүйлс байна гэж үзэж байна:

- ХХОАТ-ын тухай хуулийн 22.1.6-д “... газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээгээ үнэ төлбөргүйгээр шилжүүлэх замаар олсон орлого” гэж

¹⁴ Тухайлбал, бэлэглэлийн гэрээ, өв залгамжлах эрх, хамтран өмчлөгч өөрчлөх болон бусад гэрээ хэлцлүүд.

заасны дагуу дараах 2 эргэлзээг төрүүлж байна. Үүнд: (1) Тус чөлөөлөгдөж буй орлогод ямар төрлийн орлого хамаарах, мөн (2) газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнээс бус хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэх үед ямар төрлийн орлогод татвар ногдуулах асуудал юм.

- Биет хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод орлогын албан татвар ногдуулаагүй.
- Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос ХХОАТ тооцож буй нь хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг бусад төрлөөр шилжүүлэх замаар ХХОАТ-аас зайлсхийх боломжийг бүрдүүлж байх магадлалтай.

4.5 Шууд бус орлого, түүний үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд

ХХОАТ-ын тухай хуульд заасны дагуу шууд бус орлогод хамрагдах орлогын эх үүсвэр, түүнд албан татвар ногдуулах хувь хэмжээ болон албан татварыг ногдуулан төлөх, тайлагнах хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 14-т харуулав.

Хүснэгт 14. Шууд бус орлогын татварын зохицуулалт

Татвар ногдуулах орлого	Хувь хэмжээ	Хугацаа		Татвар төлөгч (өөрөө суутгагч)
		Ногдуулах төлөх	Тайлагнах	
Шууд бус орлого				
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй бараа, ажил, үйлчилгээний орлого	Нийт орлогын дүн нь 0-120 сая хүртэлх төгрөг байх тохиолдолд 10 хувь, 120-180 сая хүртэлх төгрөг тохиолдолд 12 сая төгрөг дээр 120 сая төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувь, 180 сая төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 сая төгрөг дээр 180 сая төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувь тус тус тооцно.	1. Монгол Улсад байрладаг ААН-д ажиллаж, Монгол Улсад байрладаггүй этгээдээс авсан ажил үүрэг гүйцэтгэхэд шууд холбогдолгүй шууд бус орлогод ногдох албан татварыг дараа сарын 10-ны дотор холбогдох төсөвт төлж, тухайн татварын жилийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ; 2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон ажил үүрэг гүйцэтгэхэд шууд холбогдолгүй шууд бус орлогод албан татвар ногдуулж, дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор.	1. Орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулна дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор. 2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад олсон ажил үүрэг гүйцэтгэхэд шууд холбогдолгүй шууд бус орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор.	1. Суутгагч 2. Татвар төлөгч

Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

Шууд бус орлого нь дараах 2 хэсгээс бүрдэнэ¹⁵. Үүнд:

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй бараа, ажил, үйлчилгээний орлого. Тухайлбал:

¹⁵ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 11 дүгээр зүйл.

- Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн;
- Орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрны хөлс, түлшний зардлын төлбөр;
- Үзвэр үйлчилгээний олговор;
- Ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр;
- Ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр;
- Арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;
- Ажил олгогчийн төлсөн хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор ажил олгогчийн төлсөн сайн дурын амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын болон мэргэжлийн хариуцлагын даатгалын хураамжаас бусад сайн дурын даатгалын хураамж;
- Гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр;
- Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр;
- Эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл;
- Дээрхтэй адилтгах бусад орлого.

2. Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа шууд бус орлого. Тухайлбал:


- Цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан;
- Амрах байр, бусад үйлчилгээгээр хангах, тухайн ажлын байранд ирэх, буцахад нэгдсэн журмаар унаагаар үйлчилсэн;
- Орон сууц худалдан авах, барихад зориулж ажилтанд арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;
- Эрүүл мэндийн байгууллагад төлсөн эмчилгээний зардалд зориулж олгосон тусламж, дэмжлэг;
- Ажил олгогчоос олгож байгаа албан томилолтын зардал;
- Хууль тогтоомжийн дагуу ажил олгогчоос олгож байгаа хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцас, хор саармагжуулах ундааны үнэ, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн зардал;
- Хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор ажил олгогчийн төлсөн сайн дурын амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын болон мэргэжлийн хариуцлагын даатгалын хураамж.

Дээрх 2 төрлийн шууд бус орлогоос зөвхөн ажил үүрэг гүйцэтгэхэд шууд холбогдолгүйгээр ажилтанд олгосон бараа, ажил, үйлчилгээний орлогод ХХОАТ ногдуулна.

Шууд бус орлогод хамаарах эх үүсвэрийн (1) татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох нь тодорхой, (2) тогтоосон орлогод ногдуулах хувь хэмжээ тодорхой, (3) ногдуулах орлогыг хэн, хэдий хугацаанд төсөвт төлөх, тайлагнах нь тодорхой байна.

Санхүү, төсвийн үүрэг: Шууд бус орлого нь сүүлийн 5 жилд дунджаар нийт улсын төсөвт ХХОАТ-аас төвлөрүүлсэн дүнгийн 2.38 хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд ХХОАТ-ын орлогын дүнд эзлэх шууд бус орлогын хувь хэмжээ буурах хандлагатай байна.

График 12. Шууд бус орлогод ногдуулсан албан татварын хэмжээ, ХХОАТ-т эзлэх хувиар, 2016-2023 он



Эх сурвалж: Төсвийн тодотгол, 2023 он

Зохицуулалтын үүрэг: Шууд бус орлогод ногдуулах албан татвартай холбоотой ямар нэгэн хөнгөлөлт чөлөөлөлт байхгүй байна.

4.6 Бусад орлогын татварын зохицуулалт, үүргийн хэрэгжилт болон анхаарах асуудлууд

ХХОАТ-ын тухай хуульд заасны дагуу бусад орлогод хамаарах 3 багц орлогын эх үүсвэрүүд байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Бусад орлогын татварын зохицуулалт

№	Татвар ногдуулах орлого	Хувь хэмжээ	Хугацаа		Татвар төлөгч (өөрөө суутгагч)
			Ногдуулах төлөх	Тайлагнах	
Бусад орлого					
1	Урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого	5 хувь (Нийт орлогын дүнгээс)	<p>1. Тухай бүр албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх</p> <p>2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулж, дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор</p>	<p>1. Улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор;</p> <p>2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч нь гадаад улсад олсон урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор ессөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.</p>	<p>1. Суутгагч</p> <p>2. Татвар төлөгч</p>

2	Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлого	40 хувь (Нийт орлогын дүнгээс)	<p>1. Тухай бүр албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх</p> <p>2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн татварын жилд гадаад улсад төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод албан татвар ногдуулж, дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор</p>	<p>1. Улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор;</p> <p>2. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч нь гадаад улсад олсон төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны хонжворын орлогод ногдуулсан албан татварын тайланг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.</p>	<p>1. Суутгагч</p> <p>2. Татвар төлөгч</p>
3	Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого	10 хувь (Нийт орлогын дүнгээс)	<p>1. Татвар төлөгч өөрийн хүсэлтээр үйл ажиллагааны орлогод хамруулан, албан татвар ногдуулан төлж болно.</p> <p>3. Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь уг зөвшөөрлийг гэрчилгээний хамт олгон, тухай бүр албан татварыг хураан авч, холбогдох төсөвт төвлөрүүлнэ.</p>	<p>1. Татвар төлөгч өөрийн хүсэлтээр үйл ажиллагааны орлогод хамруулан, албан татвар тайлагнаж болно.</p> <p>2. Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж нь хураан авсан албан татварын тайланг харьяа татварын албанд дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.</p>	<p>1. Татвар төлөгч</p> <p>2. Бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж.</p>


Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

Бусад орлогод хамаарах эх үүсвэрүүдийн (1) татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох нь тодорхой, (2) тогтоосон орлогод ногдуулах хувь хэмжээ тодорхой, (3) ногдуулах орлогыг хэн, хэдий хугацаанд төсөвт төлөх, тайлагнах нь тодорхой байна.

Гэвч ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.3-д “... спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого” нь үйл ажиллагааны орлогод хамаарах тухай заасан байгаа нь бусад орлогод хамаарах спортын тэмцээний шагнал түүнтэй адилтгах орлоготой утга давхардаж байгаа нь татвар төлөгчдийг төөрөгдүүлэх магадлалтай байна.

Санхүү, төсвийн үүрэг: Шууд бус орлого нь сүүлийн 5 жилд дунджаар нийт улсын төсөвт ХХОАТ-ын төвлөрүүлсэн дүнгийн 0.04 хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд ХХОАТ-ын орлогод эзлэх бусад орлогод ногдох албан татварын орлогын хувь хэмжээ буурчээ (График 13).

График 13. Бусад орлогод ногдох албан татварын хэмжээ, ХХОАТ-т эзлэх хувиар, 2016-2023 он



Эх сурвалж: Төсвийн тодотгол, 2023 он

Зохицуулалтын үүрэг: Бусад орлогод ногдуулах албан татвартай холбоотой дараах хөнгөлөлт, чөлөөлөлтүүд Монгол Улсад хэрэгжиж байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагналын орлогод ногдох татварын хөнгөлөлт.

Бусад орлогод хамрагдах орлогын эх үүсвэрүүдэд анхаарах зүйлс:

ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.3-т “... спортын тэмцээн, үрлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого” нь үйл ажиллагааны орлогод хамаарах тухай заасан байна. Үүнээс харахад үйл ажиллагааны орлогод хамаарах спортын тэмцээнд оролцох замаар олсон орлогод ногдох албан татвар нь 10 хувь бол бусад орлогод хамаарах спортын тэмцээний шагналд ногдох албан татвар 5 хувь байгаа нь ХХОАТ төлөхөд төөрөгдөл учруулж болзошгүй байна.

4.7 Оршин суугч бус албан татвар төлөгч

Албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна. Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчид Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон дараах нөхцөлийг хангаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамаарна.

Хүснэгт 16. Оршин суугч бус албан татвар төлөгчийн тодорхойлолт

Нөхцөлүүд	Хэрхэн тодорхойлох
Монгол Улсад үргэлжилсэн 12 сарын хугацаанд 183 хоног оршин суугаагүй	Хоногийн нийлбэрээр
Давхар татварын гэрээ байгуулсан улсын иргэний хувьд	Гэрээний 4 дүгээр зүйлд заасан этгээдээс бусад
Монгол Улсад байнга оршин суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар,НҮБ, түүний төрөлжсөн салбарт томилогдон ажиллаж байгаа	Гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн

Эх сурвалж: ХХОАТ-ын тухай хууль

Хувь хүний орлогын албан татварын хуульд оршин суугч бус татвар төлөгчийн тухай дараах заалтууд байна. Үүнд:

20.1.Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

20.2.Монгол Улсад оршин суугч этгээд болон Монгол Улсад оршин суугч бус этгээд хооронд байгуулсан аж ахуйн үйл ажиллагааны гэрээний дагуу тухайн оршин суугч бус этгээдийг төлөөлж Монгол Улсад хүрэлцэн ирж ажилласан хувь хүнд Монгол Улсад оршин суугч этгээдээс олгосон орлогыг талууд гэрээнд тусгасан байна.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан нөхцөл нь гэрээнд тодорхой тусгагдаагүй тохиолдолд гэрээний үнийн тооцоололд багтсан тухайн хувь хүний Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллахтай холбогдон гарсан зардлын дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

Мөн хуулийн 20.1-д заасан орлогын 20 хувиар албан татвар ногдуулна.

Оршин суугч бус албан татвар төлөгчийн орлогод (1) татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох нь тодорхой, (2) тогтоосон орлогод ногдуулах хувь хэмжээ тодорхой, (3) хөрөнгийн орлогыг хэн, хэдий хугацаанд ногдуулан төсөвт төлөх, тайлагнах нь тодорхой бөгөөд зарим талаар ерөнхий байна.

V. ХХОАТ-ын бодлогын хүрээнд тулгарч буй асуудлууд

Адам Смитын тодорхойлсон татварын 4 зарчмын дагуу Монгол Улсын ХХОАТ-ын шударга, эрх тэгш байдал, тохиромжтой, тодорхой байдал болон үр ашигтай байдлыг боломжит мэдээлэлд үндэслэн хэмжээний үндсэн дээр ХХОАТ-т илэрч буй 4 асуудлыг дор тодорхойлон гаргав (Хүснэгт 17).

Хүснэгт 17. ХХОАТ-т тулгарч буй асуудлууд, тэдгээрийн үүсэж буй шалтгаан болон үүсэх сөрөг үр дагавар¹⁶

Асуудал	Шалтгаан	Үүсэх сөрөг үр дагавар
Албан татвар төлөх ёстой иргэд шударга байдлаар ХХОАТ төлөх зарчим зөрчигдсөн.	<ol style="list-style-type: none"> 1. Татварын талаарх мэдлэг мэдээлэл дутмаг 2. Татварт хандах сөрөг хандлага нэмэгдэж байна 3. Татвараас зайлсхийх боломжийг бүрдүүлж байна. 	<ol style="list-style-type: none"> 1. ХХОАТ санхүү, төсвийн үүргээ биелүүлж чадахгүй болох эрсдэл үүсэж болзошгүй.
ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт уян хатан биш.	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзан үзэлгүй зөвхөн олж буй орлогод хөнгөлөлт, чөлөөлөлтийг нөхцөлт бусаар тодорхойлсон. 	<ol style="list-style-type: none"> 1. ХХОАТ нийгмийн болон зохицуулалтын үүргээ биелүүлж чадахгүй байдалд хүрэх боломжтой. 2. Ингэснээр эргээд иргэдийн татварт хандах сөрөг хандлагыг нэмэгдүүлж, татвар төлөлт буурах эрсдэл үүсэх магадлалтай.
ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн ангилал хэт ерөнхий, тодорхой бус.	<ul style="list-style-type: none"> • ХХОАТ-ын тухай хуульд тодорхой бус тусгагдсан 	<ol style="list-style-type: none"> 1. Татвар төлөгчдийн дунд тодорхойгүй, ойлгомжгүй байдал үүсэх. 2. Албан татварын шударга байх зарчим зөрчигдсөөр байна.
ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн хувьд хэрхэн тайлагнах, төлөх, тооцоолох нь хялбар, ойлгомжтой биш.		

Эх сурвалж: Судлаачдын дүгнэлт

5.1 Албан татвар төлөх ёстой иргэд шударга байдлаар ХХОАТ төлөх зарчим зөрчигдсөн.

Эдийн засгийн үйл ажиллагаанд давамгайлж буй хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, ан агнуур (13.1 хувь) болон бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ (16.1 хувь)-ний салбаруудад хөдөлмөр эрхлэгчдийн тоо мөн адил өндөр байна. Тодруулбал, 2022 оны байдлаар бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээнд 146,236 хүн, хөдөө аж ахуй, ойн

¹⁶ ХХОАТ тулгарч буй асуудлын шалтгааныг энэхүү судалгааны ажлын 5.1, 5.2, 5.3-т тайлбарлав.

аж ахуй, загас агнуур, ан агнуурийн салбарт 293,974 хүн тус тус хөдөлмөр эрхэлж байна¹⁷. Дээрх үйл ажиллагааны салбарт ажиллаж буй татвар төлөгчдийн дийлэнх хувь нь хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаанд хамрагдах хувиараа бизнес эрхлэгч, худалдаачид, малчид, тариаланчид юм. Гэвч 2018 оноос хойш ХХОАТ-т эзлэх цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан албан татварын хэмжээ тасралтгүй өсөж, сүүлийн 5 жилийн дунджаар ХХОАТ-ын 75 хувийг эзэлж байна. Энэ нь хувиараа бизнес эрхлэгч, худалдаачдын борлуулалтын орлого болон малчдын мал болон малын мах, сүү, арьс, шир, ноос, ноолуур, болон бусад түүхий эд бүтээгдэхүүний борлуулалтын орлого зэрэгт ногдох албан татвар төлөх, тайлагнах гүйцэтгэл, хэрэгжилт дутмаг буйг илтгэж болох юм. Иймд хэрэгжилтийг хянах боломж илүү өндөр, хууль тогтоомжид тодорхой тусгагдсан буюу цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох албан татвар төлөгчдөд татварын ачаалал илүү оногдож байна.

Татвар төлөгч бүгд шударгаар өөрт ногдох албан татварыг цаг тухайд нь төлж байх нь татварын үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлнэ. Гэвч Монгол Улсад татвар төлөгч бүр эрх тэгш, шударгаар татвар төлөхгүй байгаа нь дараах 3 шалтгаанаас ерөнхийлөн үүсэж байна.

1. Татвар төлөх талаарх мэдлэг мэдээлэл дутмаг.

Татварын ерөнхий газрын Орлогын хяналт буцаан олголтын хэлтэс (ОХБОХ)-ийн дарга Д.Тунгалагийн мэдээлснээр “Татварын албанд нийт 2.9 сая иргэн татвар төлөгчөөр бүртгэлтэй байдаг. ...2022 оны ХХОАТ-ын тайланг 293,963¹⁸ иргэн ирүүлсэн”. Энэ нь Монгол Улсын хөдөлмөр эрхлэх боломжтой нийт хүн амын 10 хувийг бүрдүүлж байгаа нь иргэдийн дундах татвар хэрхэн тайлагнах, өөрөө мэдүүлэн татвар хэрхэн төлөх зэрэг мэдээ мэдээлэл дутмаг байгааг илтгэж байна. Иймд татвар хэрхэн тайлагнах, болон төлөх талаарх мэдээ, мэдээллийг сурталчлан түгээх, татвар тайлагнах, төлөхийн үр ашгийг татвар төлөгчдөд ойлгуулах шаардлагатай байна.

2. Татварт хандах сөрөг хандлага нэмэгдэж байна.

Бүх төрлийн албан татвар нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийн гол түлхүүр болж байдаг. Гэвч иргэдийн дунд албан татвар өөрийн гүйцэтгэх ёстой үүргийг хангалттай сайн гүйцэтгэж чадахгүй байгаа гэсэн үзэл давамгайлж эхэлбэл татвараас зайлсхийх, татвар төлөхгүй байх сэдэл үүсэх зэрэг сөрөг нөлөөг бий болгож байдаг. Тухайлбал Монгол Улсад дараах шалтгааны улмаас татварт хандах сөрөг хандлага нэмэгдэж байх магадлалтай байна. Үүнд:

¹⁷ ҮСХ, УБ., 2023 он.

¹⁸ Ikon.mn (2023 оны 5-р сарын 1), Татварын ерөнхий газрын ОХБОХ-ийн дарга Д.Тунгалагаас тодрууллаа, “Орон сууц худалдан авсны болон оюутны сургалтын төлбөрийн ХХОАТ-ын буцаан олголтыг шилжүүлж эхэллээ” (ikon.mn)

- *Санхүүгийн мэдлэг.* 2022 оны Монгол Улс даяар явуулсан “Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа”-ны үр дүнд иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролын чадамжийн түвшин 9.9 оноо буюу авч болох боломжит хамгийн өндөр оноо (20)-ны 49.5 хувь байсан байна. Тус судалгааны үр дүнгээс харахад иргэдийн дунд арилжааны банкны бүтээгдэхүүн үйлчилгээгээр дийлэнх олонхын санхүүгийн мэдээлэл хязгаарлагдаж буйг харж болно. Иймд санхүүгийн тухай ойлголт, ялангуяа татварын тогтолцоо, түүний хэрэгцээ шаардлага, болон нийгэмд үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдлэг, мэдээлэл сул байгаа нь татварын талаарх сөрөг хандлага бий болоход тодорхой хэмжээний нөлөө үзүүлж байж болзошгүй юм.
- *Төрийн үйлчилгээ.* Албан татвар нь төсвийн орлогын дунджаар 90 орчим хувийг эзэлдэг. Тэрхүү орлогыг Засгийн газар хэрхэн зарцуулж буйгаас татварт хандах хандлага ихээхэн нөлөөлнө. Тодруулбал, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээ болох дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн хөтөлбөрүүд зэргийн хүртээмж, чанар болон бодит үр өгөөжөөс иргэд дүгнэлт хийж байдаг.

Гэвч Монгол Улсын хувьд 2022 оны “Ажлаа хий!” үнийн хөөрөгдөлтийн эсрэг болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн асуудлуудыг хөндсөн тайван жагсаалын үеэр иргэд санал бодлоо илэрхийлсэн ярилцлагад төрийн үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээний талаар “... нөхөр бид хоёрын цалин нийлээд дундаж давхаргад бол хүрдэггүй ... гэхдээ бид хоёр 3 төрлийн татварт 14,153,000 төгрөг төлсөн байна. ... гэхдээ манай хүүхэд цэцэрлэгт явж чадаагүй, нөгөө сугалаанд хожоогүй, өвдөөд эмнэлэгт хэвтэе гэхэд ор олдоогүй ...¹⁹”, “Бид энэ нийгэмд 2 сая төгрөгийн цалин авдаг бол ... НДШ-11.5 хувь, ХХОАТ-т 10 хувь, НӨАТ гэж 10 хувь аваад, улирлын эцсээр хэрүүл уруултайгаар 2 хувийг нь буцааж өгөөд, 8 хувь ... төлөөд ... та өөрөө 1,465,560 төгрөгтэй л үлдлээ дээ” гэх зэрэг сэтгэгдлүүд хөвөрсөн байна. Мөн Улаанбаатар хотод 2023 оны наймдугаар сарын 5-ны өдрийн үерийн аюулт үзэгдлийн улмаас 365 айл өрх, 25 ААН, 105 хөдлөх эд хөрөнгө өрт өртөж, 3 хүний амь нас эндсэн²⁰ нь иргэдийн дунд дэд бүтцийн асуудлын талаар цахим орчинд хэлэлцэх шалтаг болсон. Эдгээр асуудлын улмаас иргэд төрийн үйлчилгээг чанаргүй, иргэдэд хангалттай хүртээмжтэй байж чадахгүй байна хэмээн үзэн, татварын талаарх сөрөг хандлага нийгэмд нэмэгдсэн байх магадлалтай.

- *Эдийн засгийн хүндрэл.* Төрийн үйлчилгээнээс үл хамааран Монгол Улсын эдийн засагт тулгарч буй эрсдэлт хүчин зүйлс нь иргэдийн дунд эдийн засгийн өсөлт сул, үүнээс үүдэн иргэдийн амьжиргааны түвшин сайжрахгүй,


¹⁹ Focus.mn, 2022, <https://www.facebook.com/100003802673827/videos/352183713613073/>

²⁰ News.mn, 2023, “Монгол Улсын шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайханы мэдэгдэл”

нийгэм, санхүүгийн асуудлууд дорвитой шийдэгдэхгүй байна хэмээх үзэл бий болсноор иргэдийн татварт хандах хандлагад сөргөөр нөлөөлж байх магадлалтай байна.

- *Төрд итгэх итгэл.* Татвараас бүрдэж буй төсвийн орлогыг Засгийн газар нь ил тод, үр дүнтэй удирдаж байвал иргэдийн Төрд итгэх итгэл нэмэгдэж, татвар төлөх эерэг хандлага бий болно. Хэрэв төсвийн зарлага нь ил тод бус бөгөөд зарцуулалт үр ашиг султай, авлига, хээл хахуулийн түвшин өндөр бол иргэдийн дунд татвар төлөх эсэхдээ илүү их эргэлзэх хандлага ажиглагддаг. Монгол Улсын хувьд 2020 оноос хойш цахим орчинд Сүхбаатарын талбай дээрх усан оргилуур, Хэнтий аймаг дахь Андлалын хөшөөг 2 тэрбум төгрөгөөр барьсан болон түүнийг буцаан нураасан зэрэг асуудлыг нийтээр хэлэлцэн, төсвийн үр ашиггүй зарцуулалтад сэтгэл дундуур буйгаа илэрхийлэн, давлагаа үүсээд амжсан. Энэ мэт бүтээн байгуулалтын ажлуудаас үүдэн иргэдийн дунд төрд итгэх итгэл буурах хандлага ажиглагдаж байгаа, мөн Монгол Улсын авлигын индекс 67²¹ (Энэ нь дэлхийн дунджаас 10, Азийн дунджаас 7.2 нэгжээр тус тус их байна) байгаа нь эргээд татвар төлөх хандлагад сөргөөр нөлөөлж байна гэж үзэж болохоор байна.

График 14. Монгол Улсын авлигын индекс, 2004-2022 он



Эх сурвалж: Worlddata.info (2022 он)

Иймд ХХОАТ төлөлтийг нэмэгдүүлэх, шударга байдлыг хангахад дээр дурдсан татварт хандах хандлагад сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг засварлах, иргэдэд зөвөөр ойлгуулах, мөн түүнчлэн ХХОАТ-ыг үр ашигтайгаар зарцуулах зэрэг ажлыг чухалчлан авч үзэх шаардлагатай байна.

²¹ Worlddata.info, 2022, Монгол Улсын авлигын индекс, <https://www.worlddata.info/asia/mongolia/corruption.php>

3. Татвараас зайлсхийх боломжийг бүрдүүлж байна.

Монгол Улсын ХХОАТ-ын тухай хуульд татвар ногдуулах орлогын эх үүсвэрүүд дутмаг, зарим тохиолдолд хэт ерөнхий мөн тодорхой бус тусгагдсан болон хяналтын тогтолцоо сул байдал ажиглагдаж байгаа нь татвар төлөхгүй байх, мөн татвараас зайлсхийх боломжийг бүрдүүлж байж болзошгүй юм. Иймд ХХОАТ-ын тухай хуульд орлогын эх үүсвэрүүдийг нарийн, тодорхой тусгах шаардлага үүсэж байна.

Хэрэв ХХОАТ-ыг шударгаар төлөхгүй байх нөхцөлийг үүсгэж буй дээрх 3 шалтгааныг засахгүй, энэ асуудал үргэлжилсээр байх нь ХХОАТ санхүү, төсвийн үүргээ биелүүлж чадахгүй болох эрсдэл үүсэх сөрөг үр дагавартай.

5.2 ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт иргэдийн санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзаж үзээгүй.

Монгол Улс өнөөгийн байдлаар “Хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн өндөр өсөлтийг тогтвортой хадгалах, өсөлтийн үр дүнд дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх, хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжиж, нийгмийн орлого багатай дундаж болон эмзэг давхаргын амьдралын доод түвшнийг (орон сууц, сурах, хөдөлмөр эрхлэлт гэх мэт) хангах, орлогын ялгаварт байдлыг багасгах зорилтын хүрээнд хувь хүний дээрх орлогын төрөл болон бараа, үйлчилгээг татвараас хөнгөлж, чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлж байна”. Эдгээр зорилтын хэрэгжилтийг харгалзан авч үзвэл:

- *Хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжих.* Хүний хөгжил, боловсролыг дэмжих зорилгоор сургалтын төлбөртэй тэнцэх орлогод албан татварын хөнгөлөлт эдлүүлдэг. Монгол Улсад 2022-2023 оны хичээлийн жилд нийт их, дээд сургууль, коллежийн 145,267 суралцагч²² суралцаж байгаагаас 2023 онд сургалтын төлбөрийн буцаан олголтыг 21,452 иргэнд олгосон нь нийт суралцагчдын ердөө 14.8 хувь байгаа нь тус боловсролыг дэмжих бодлогын хүртээмж тааруу байгааг илтгэж байна.
- *Нийгмийн орлого багатай дундаж болон эмзэг давхаргын амьдралын доод түвшнийг (орон сууц, сурах, хөдөлмөр эрхлэлт гэх мэт) хангах.* Тус зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ХХОАТ-ын бодлого, зохицуулалт нь зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний орлогод чөлөөлөлт үзүүлэхээс өөр зохицуулалт байхгүй байна. Харин орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд анхлан байр, хувийн орон сууц болон нийтийн орон сууц барих болон худалдан авахтай холбоотой гарсан зардлын нийт дүнтэй тэнцэх орлогод ногдох хөнгөлөлт үзүүлж байна. Энэ нь орлого их байх тусам хөнгөлөлт илүү

²² Боловсрол, шинжлэх ухааны яам, УБ., 2023 он.

их эдлэх боломжийг бий болгож байна гэсэн үг юм. Гэвч олон улсад аливаа хөнгөлөлтөд нийгмийн сегмент, иргэдийн санхүүгийн нөхцөл байдал болон бусад харгалзах хүчин зүйлсийг авч үзсэнээр дундаж давхаргыг нэмэгдүүлэх, нийгмийн орлого багатай давхаргын амьдралын доод түвшнийг хангах болон орлогын ялгавартай байдлыг багасгах боломжийг олгодог энэ ойлголт манай улсын орон сууцжуулах бодлогын хүрээнд дутмаг байдал ажиглагдаж байна.

- *Орлогын ялгаварт байдлыг багасгах.* Манай улсын орлогын тэгш бус байдлын индекс нь сүүлийн 28 жилийн турш 30.3-аас 35.8-ын хооронд хэлбэлзэж ирсэн буюу орлогын тэгш бус байдал сайжрахгүй байгаа нь нэг талаас тус зорилтын хэрэгжилтэд чиглэсэн бодлого, арга хэмжээ хангалтгүй байгааг илтгэж болох юм.

Монгол Улс дээрх зорилго, зорилтод хүрч чадахгүй байгаа нь эрх агуулагчдын эмзэг байдлыг оновчтой тодорхойлоогүй, иргэдийн санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзан үзэлгүй зөвхөн олж буй орлогод хөнгөлөлт, чөлөөлөлтийг нөхцөлт бусаар тодорхойлж байгаагаас шалтгаалж байж мэдэх юм.

Гэвч тус асуудлыг шийдвэрлэхгүй байх нь орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлэх, нийгмийн эмзэг давхаргын амьдралын доод түвшнийг хангаж чадахгүй байх, мөн энэхүү нийгмийн болон зохицуулалтын үүргээ биелүүлж чадахгүй байдлаас үүдэн иргэдийн дундах татварт хандах сөрөг хандлагыг нэмэгдүүлж, татвар төлөлт буурах зэрэг эрсдэл үүсэх сөрөг үр дагавартай.

5.3 ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн ангилал хэт ерөнхий, тодорхой бус.

ХХОАТ-ын тухай хуульд зааснаар 6 ангилал бүхий албан татвар ногдуулах орлогын эх үүсвэрийг хамруулна. Гэвч одоогийн хэрэгжиж буй хууль тогтоомжид тулгарч буй энэхүү асуудал нь дараах хэлбэрээр илэрч байна. Тухайлбал:

1. Үйл ажиллагааны орлогын ангилал нь хэт өргөн цар хүрээг хамарсан нь тус ангилалд багтах бүх орлогын эх үүсвэрт хяналт тавих боломжийг бууруулж, татвар төлөгчдөд татварт хамрагдах эсэх талаарх ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Мөн үүнээс үүдэн зах зээлд шинээр бий болж буй ажлын байр, үйл ажиллагаа эрхлэлтийг бүрэн хамруулж чадахгүй байна.
2. ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.3-т "... спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого" нь үйл ажиллагааны орлогод хамаарах тухай заасан байгаа нь бусад орлогод хамаарах спортын тэмцээний шагнал түүнтэй адилтгах орлоготой утга давхардаж байна.
3. Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогоос ХХОАТ тооцож буй нь хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг бусад төрлөөр шилжүүлэх

замаар ХХОАТ-аас зайлсхийх боломжийг бүрдүүлж байх магадлалтай байна.

ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн ангилалд илэрч буй дээрх асуудлыг шийдвэрлэхгүй байх нь (1) татвар төлөгчдийн дунд тодорхойгүй, ойлгомжгүй байдал нэмэгдэх, (2) татвар төлөгчдийг татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлэх, (3) ингэснээр татварын шударга байх зарчим зөрчигдсөөр байх зэрэг сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй байна.

5.4 ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн хувьд хэрхэн тайлагнах, төлөх, тооцоолох нь хялбар, ойлгомжтой биш.

ХХОАТ-ын тухай хуульд тулгарч буй энэхүү асуудал нь дараах хэлбэрээр илэрч байна. Тухайлбал:

1. ҮХХ-ийн түрээсийн орлогыг ногдуулан төлөх, тайлагнах хэрэгжилт болон түүний хяналт хангалтгүй байна.
2. ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.3-т "... спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого" нь үйл ажиллагааны орлогод хамаарах тухай заасан байна. Үүнээс харахад үйл ажиллагааны орлого хамаарах спортын тэмцээнд оролцох замаар олсон орлогод ногдох албан татвар нь 10 хувь бол бусад орлогод хамаарах спортын тэмцээний шагналд ногдох албан татвар 5 хувь байгаа нь ХХОАТ төлөхөд төөрөгдөл үчрүүлж болзошгүй байна.
3. Үйл ажиллагаа эрхэлдэг иргэд бүртгэлээ хэрхэн хөтөлж орлого, зардал, татвараа тодорхойлох нь тодорхойгүй, хүндрэлтэй байна.
4. Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлогыг хэн, хэдий хугацаанд ногдуулан төсөвт төлөх, тайлагнах нь ХХОАТ-ын тухай хуульд тодорхой бус байна.

VI. ХХОАТ-ын бодлогод тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбар

6.1 Олон улсын түршлагаас суралцах нь

Дээр тодорхойлсон асуудлуудын хүрээнд олон улсын сайн түршлага болсон улсуудын жишээг судалж Монгол Улсын онцлогт тохирсон шийдлийг судлаачдын багийн зүгээс тодорхойлсон болно.

Казахстан Улс - Казахстан Улсын татварын нийт орлогын бүтцийг харвал 2021 оны байдлаар 29 хувийг ААНОАТ, 26 хувийг бүтээгдэхүүн, үйлчилгээний бусад татвар, 21 хувийг НӨАТ, 6 хувийг НДШ, 9 хувийг ХХОАТ тус тус бүрдүүлж байна²³. ХХОАТ-ийн бодлого, зарчмууд “Татвар ба төсөвт төлөх бусад төлбөрийн тухай хууль” (2023 оны тавдугаар сард нэмэлт, өөрчлөлт орсон)-д тодорхойлогдсоны дагуу хэрэгждэг бөгөөд орлогын түвшнээс үл хамаарсан 10 хувийн тогтмол татварыг ногдуулдаг.

Уул уурхай, байгалийн баялагт түшиглэсэн эдийн засаг, нийгмийн шилжилт зэрэг олон талаар Монгол Улстай ижил төстэй Казахстан улсын ХХОАТ-ын бодлогод сүүлийн жилүүдэд хэд хэдэн өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ **Иргэд нь өөрөө татвараа тайлагнадаг.** Тус улсын оршин суугчид нь татварын 240.00 маягтад заасан орлого болон өөр улс оронд ажиллаж олсон орлогоо өөрөө тайлагнаж төлөх үүрэгтэй. Харин оршин суугч бус хүмүүс тайлант жилийн хугацаанд татвар ногдуулаагүй Казахстаны эх үүсвэрийн орлого (хөрөнгийн олз, ногдол ашиг, хүү, өмч хөрөнгийн орлого, түрээсийн орлого гэх мэт)-ын тайланг жил бүр тайлагнана.
- ✓ **Нийтийн мэдүүлгийн хууль (Universal Filing Law).** Тус хууль нь 2021 онд батлагдаж, мөн энэ үеэс эхлэн төрийн албан хаагчдын дунд хэрэгжиж эхэлсэн ба 2023 онд хувийн салбарын албан хаагчдад үе шаттайгаар үйлчилж эхлээд байна. Харин 2024 онд ААН-ийн захирал, үүсгэн байгуулагчид, 2025 онд дөрөвдүгээр шат буюу бүх иргэд хамрагдахаар төлөвлөгдөж байна. Тус хуулиар дээрх бүлэг хүмүүс үе шаттайгаар хуримтлагдсан хөрөнгө, өр төлбөрийн мэдүүлэг (Маягт 250.00), Хөрөнгө орлогын мэдүүлэг (Маягт 270.00) гэсэн маягтуудыг бөглөх замаар хуулийн хэрэгжилтийг хангана. Гэсэн хэдий ч, хэрэв хувь хүн гадаадын орлогын албан татварын хөнгөлөлт эдлэхийг хүсэж байгаа бол 240.00 маягтаар хувь хүний орлогын албан татварын мэдүүлэг өгөх ёстой.
- ✓ **Орлогын тохируулга.** Дараах төрлийн орлогыг татвар ногдуулахаас өмнө тохируулга хийж хөнгөлнө.

²³ Ази, Номхон далайн орнуудын орлогын статистик – Казахстан, ЭЗХАБ, 2023 он.

- a. Хүүхэд болон хэн нэгнээр тэтгүүлж буй хүмүүст олгосон тэтгэмж;
- b. Иргэдийн дотоодын банкны хадгаламж, өрийн үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, төлөөлөгчийн бонд зэрэгт төлсөн хүү;
- c. Казахстан Улсын нутаг дэвсгэрт идэвхтэй тендер зарлаж байгаа хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн үнэт цаасны ногдол ашиг болон хүү;
- d. Цэргийн алба хаагч, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын орлого;
- e. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүй сугалааны хонжвор;
- f. Нийтийн ажил, мэргэжлийн сургалтыг гүйцэтгэхтэй холбоотой төлбөр, болон буцалтгүй тусламж (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй);
- g. Холбогдох бичиг баримт бүрдүүлсэн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээний төлбөр.

Сингапур Улс - Сингапур Улс нь өрсөлдөх чадвартай татварын тогтолцоо, улс төрийн тогтвортой байдал, бизнест ээлтэй бодлого, амьдралын чанар зэрэг олон давуу тал, онцлогийг цогцлоосон ба татварын өргөн бааз суурийг бүрдүүлж, татвараас зайлсхийх эрсдэлийг бууруулж, эдийн засгийн оролцоог дэмждэг татварын үр ашигтай системтэй олон улсын сайн жишиг юм. Сингапур Улсын ХХОАТ-ын тогтолцоо нь хэд хэдэн онцлогтой. Эдгээрээс дурдвал:

- ✓ **Энгийн байдал:** Сингапур Улсын татварын систем нь энгийн бөгөөд үр ашигтай байдгаараа олон улсад жишиг болж танигдсан. Энэ нь хувь хүмүүст татварын үүргээ ойлгож, биелүүлэхэд хялбар нөхцөл байдлыг бий болгож өгсөн байдаг.
- ✓ **Татварын хувь хэмжээ харьцангуй бага.** Сингапур нь бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад хувь хүний орлогын албан татварын хэмжээ харьцангуй бага. Энэ нь гадаадын чадварлаг ажиллах хүчийг татах, цаашлаад эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой байдаг байна.
- ✓ **Төвийн тусламжийн сан (CPF²⁴)-гийн шимтгэл.** CPF нь Сингапурын иргэд болон байнгын оршин суугчдад зориулсан нийгмийн даатгалын хуримтлалын хөтөлбөр юм. Хувь хүний орлогын тодорхой хэсэг нь энэхүү санд төвлөрч тэтгэвэр, эрүүл мэнд, орон сууцны тэтгэмж зэргээр татвар төлөгчид буцаж очдог.
- ✓ **Гадаадын мэргэжилтнүүдэд зориулсан схемүүд.** Сингапур нь гадаадын мэргэжилтнүүд болон гадаадын иргэдэд зориулсан энгийн оршин суугч бус иргэний (NOR²⁵) схем, Дэлхийн хөрөнгө оруулагчдын хөтөлбөр (GIP²⁶) зэрэг сонирхолтой татварын тогтолцоог бүрдүүлсэн байдаг.²⁷
- ✓ **Олон төрлийн үр ашигтай, оновчтой татварын хөнгөлөлт, чөлөөлөлт.**

²⁴ CPF – Central Provident Fund

²⁵ NOR – Not Ordinarily Resident

²⁶ GIP – Global investor Program

²⁷ <https://www.iras.gov.sg/home>

Ирланд Улс - Ирланд улсын ХХОАТ нь PAYE, USC, PRSI гэсэн үндсэндээ гурван татвараас бүрдэнэ. Хөдөлмөр түүнтэй адилтгах орлогыг ажил олгогч цалингаас шууд суутган авдаг ба үүнийг “Орлого олох тутам төл” (Pay as you earn) буюу PAYE гэж нэрлэдэг. Мөн тухайн татвар төлөгчийн хувийн нөхцөл байдлаас хамаарч татварын хэмжээ буурах боломжтой хөнгөлөлтүүдийг өргөн хүрээнд ашигладаг байна. Ирланд Улсын ХХОАТ-ын системд татварыг хэрхэн тооцож, хувь хүнээс авахыг тодорхойлдог хэд хэдэн онцлог шинж чанарууд байдаг. Эдгээрээс дурдвал:

- ✓ **Universal Social Charge²⁸ (USC):** USC нь 2011 онд Ирландад татварын тогтолцоог хялбарчлах, нийгмийн халамжийн хөтөлбөр, төрийн үйлчилгээг дэмжих зорилгоор нэвтрүүлсэн татвар юм. Хэрэв татвар төлөгчийн нийт орлого жилийн 13,000 еврогоос дээш бол USC-ийг төлнө.
- ✓ **Татвараа өөрөө тайлагнах.** Хувиараа хөдөлмөр эрхлэгчид орлогын албан татвараа өөрсдөө жил бүр тооцож, төлөх үүрэгтэй. Татвар ногдуулах орлогод бизнесийн ашиг болон бусад орлого хамаарна. Татвараа хугацаанд нь мэдүүлж, төлөлтөө хийгээгүй тохиолдолд дараах байдлаар торгууль тооцдог. Үүнд:
 - 2 сараас бага хугацаанд мэдүүлгээ хоцроосон тохиолдолд татварын 5 хувь (дээд тал нь 12,695 евро хүртэл),
 - 2 сараас дээш хугацаагаар хоцроосон тохиолдолд татварын 10 хувь (дээд тал нь 63,485 евро хүртэл)

Мөн зарим тохиолдолд төлбөрөө хожимдуулсан тохиолдолд өдрийн хүүг төлөх хүртэл хариуцлага ногдуулдаг.

- ✓ **Хувь хүний нөхцөл байдлыг олон талаас нь бодолцож үзсэн хөнгөлөлтийн бодлого.**

Хувь хүний нөхцөл байдлыг татварын бодлогод тусгахдаа санхүү, нийгмийн олон талт нөхцөл байдлыг харгалзах байдлаар мэдрэмжтэй байх нь шударга ёс, нийгмийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлдэг. Нөгөө талаас аливаа татварын бодлого, түүний дотор ХХОАТ-ын хөнгөлөлт үр дүнтэй байх нь түүний хэрэгжилт, үр нөлөөг тасралтгүй үнэлэхээс ихээхэн хамаардаг болохыг мөн Ирландын туршлага харуулдаг. Ирланд Улсад нийт 29 төрлийн хөнгөлөлт идэвхтэй хэрэгждэг бөгөөд гэрлэлтийн байдал, хүүхдийн тоо, хэн нэгний асран халамжилж буй эсэх зэрэг олон талт байдлыг харгалзсан байна (Хавсралт 2).

²⁸ Нийтийн нийгмийн төлбөр - хөрөнгийн тодорхой хөнгөлөлтийг эдэлсний дараах нийт орлогод төлөх татвар юм).

6.1.1 Албан татварын шударга байх зарчмыг хангах.

Казахстан Улсын түршлага - Казахстан Улс нь ил тод байдлыг хангах замаар татварын шударга ёсны зарчмыг хангаж байна. Тус улс татварын шударга, тэгш тогтолцоог хангах хэд хэдэн арга хэрэгсэл, стратегийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- ✓ *Татвараа ил тод тайлагнах шаардлага;*
- ✓ *Олон улсын хамтын ажиллагаа. Казахстан улс татвараас зайлсхийхтэй тэмцэх, ил тод байдлыг дэмжих чиглэлээр олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Тайлангийн нийтлэг стандарт (CRS) зэрэг санаачилгад оролцож, олон улсын стандартыг дагаж мөрдөх нь хил дамнасан татвараас зайлсхийхээс сэргийлж, дэлхийн татварын шударга орчныг бүрдүүлдэг;*
- ✓ *Дижиталчлал. Татварын удирдлагыг цахимжуулснаар үйл явцыг оновчтой болгож, хүний алдаа гарах боломжийг багасгаж, татвар хураах үр ашгийг дээшлүүлж, цаашлаад татварын хууль тогтоомжийг шударга, тууштай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.*

Сингапур Улсын түршлага - Сингапур Улс нь өөрийн улсын онцлогт тохирсон татварын бодлогыг хэрэгжүүлдэг ба татварыг шударга хураах зарчмыг баримталж түүний хэрэгжилтийн хүрээнд олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тэдгээрээс онцолбол:

- ✓ *Татварын ногдох орлогын төрлүүдийг тодорхой болгох, шинээр бий болж буй төрлүүдийг нэмэх;*
- ✓ *Татвар төлөх эерэг хандлагыг түгээх, сурталчлах, татварын боловсрол олгох олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах;*
- ✓ *Шаталсан татварын тогтолцоог сайжруулах;*
- ✓ *Оновчтой хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого хэрэгжүүлэх, тэдгээрт хяналт тавих, шинэчлэх.*

Боломжит бүх төрлийн татвар ногдох эх үүсвэрүүдийг тодорхойлж, хэрхэн ногдуулах арга зүйг хуульдаа нарийвчлан тодорхойлсон байдаг ба тогтмол судалгаа, шинжилгээг хийдэг байна. Мөн хөнгөлөлт, чөлөөлөлт болон шаталсан татварын бодлогоор дамжуулан иргэдэд ногдох татварын ачааллыг тэнцвэржүүлж байгаа нь ХХОАТ-ыг илүү үр өгөөжтэй болгож байна.²⁹

Ирланд Улсын түршлага - Ирланд Улс нь татварыг шударга ногдуулж хураах зарчмыг баримталж, түүний хүрээнд олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Тэдгээрээс онцолбол:

²⁹ <https://www.iras.gov.sg/home>

- ✓ Шаталсан татварын тогтолцоог хэрэгжүүлэх
- ✓ Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогоо тухайн улсын иргэдийн онцлогт тохируулан тодорхойлох, сайжруулах
- ✓ Татварын бааз сууриа оновчтойгоор нэмэгдүүлэх
- ✓ Татварын боловсролыг сайжруулах, бага наснаас тэдгээрийг сургалтын хөтөлбөрт оруулах.

Ирланд улс нь Сингапур Улстай ижил хувь хүний нийгмийн болон санхүүгийн, мөн гэр бүлийн нөхцөл байдлыг татвар ногдуулахдаа авч үздэг нь иргэдэд очих татварын ачааллыг тэнцвэржүүлдэг байна. Мөн бага наснаас нь татварын боловсролыг хүүхдэдээ олгодог ба энэ нь тухайн улсын иргэд татварын тухай өндөр мэдлэгтэй болж төлөвших суурийг тавьж, цаашлаад татварын орлогын тайлагнал өндөр байх нэг шалтгаан болж байна.

6.1.2. ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөд иргэдийн санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг харгалзан үзэх.

Казахстан Улсын туршлага - Казахстан Улс нь иргэдийн нийгэм, эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч, санхүүгийн бэрхшээлтэй тулгарч болзошгүй хүмүүст тусламж үзүүлэх зорилготойгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлж байна. Ингэхдээ бага орлоготой иргэд, асран хамгаалагчтай гэр бүл эсвэл эдийн засгийн тодорхой хүндрэлтэй тулгарсан хүмүүс гэх мэт тодорхой бүлгийг дэмжихэд чиглэж байна. Энэ нь хүн амын давхаргын хэрэгцээ, санхүүгийн чадавхыг харгалзан илүү тэгш, хүртээмжтэй татварын тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Тухайлбал, даатгалын шимтгэл, эмнэлгийн зардал, ипотекийн зээлийн хөнгөлөлт, энтрепренерийн хөнгөлөлт, гадаад татварын хөнгөлөлт зэрэг хөнгөлөлтүүд багтаж байна.

Сингапур Улсын туршлага - Сингапур Улсын хувьд хөнгөлөлт болон чөлөөлөлтүүд нь бусад улсуудтай харьцуулахад харьцангуй олон байдаг ба энэ нь ард иргэдээ ажил хөдөлмөр эрхлэхэд том дэмжлэг болдог байна. Энэхүү ард иргэддээ үзүүлж буй дэмжлэг нь эргээд ажилгүйдлийн түвшнийг бууруулж, улсын эдийн засагт сайнаар нөлөөлдөг байна.

Татвар ногдох орлогын эх үүсвэртэйгээ нягт холбогдсон хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг Сингапур улсын зүгээс тодорхойлсон ба нийгмийн халамж, дэмжлэг багатай ч ХХОАТ төлөгчдийг нийгмийн байр суурь, гэр бүлийн байдал, тэжээгчдийн тоо зэргийг харгалзан үзэж татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд үзүүлдэг нь оновчгүй олон бодлого хэрэгжүүлснээс урт хугацаанд илүү өгөөжтэй байж болохоор байна. Тухайн улс нь нийт 10 төрлийн орлогод хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж буй ба дэлгэрэнгүйг Хавсралт 1-т оруулав.³⁰

³⁰ <https://www.iras.gov.sg/home>

Ирланд Улсын түршлага - Ирланд Улсын хувьд тодорхой бүлгүүдэд үзүүлэх дэмжлэг сайн байна. Татварын хөнгөлөлт нь эцэг эх, асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт тодорхой бүлэгт чиглэж, хэрэгцээтэй хүмүүст нь санхүүгийн тусламж үзүүлж чаддагаараа нэг талаас орлогын тэгш бус байдлыг бууруулахад тусалж байгаа бол нөгөө талаас татвараа үнэнч шударгаар өөрөө тодорхойлон төлөх байдлыг урамшуулан дэмжих зорилготой байна. Ирланд Улсад нийт 29 төрлийн хөнгөлөлт байгаа ба тэдгээрийн дэлгэрэнгүйг Хавсралт 2-т оруулав.

6.1.3 ХХОАТ ногдох орлогын эх үүсвэрийн ангиллыг тодорхой болгох.

Казахстан Улсын түршлага - Казахстан улсын хууль тогтоомжийн нарийвчлал, төрийн үйлчилгээний харилцааны стратегийн хослолоор ХХОАТ-ын орлогын эх үүсвэрийг тодорхой болгоход анхаардаг. Татвар ногдох орлогыг тодорхой, ойлгомжтой байлгах нь татвар төлөгч болон татварын албанд татварын тайланг тууштай, ил тод, үнэн зөв гаргахад чухал ач холбогдолтой юм.

ХХОАТ-ын татвар ногдох орлого:

- 1. Ажил эрхлэлтийн орлого.** Үүнд ажилтны ажил олгогчоос мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр (ажил олгогчоос олгосон байр, тэтгэмж, нөхөн олговор, компанийн өгсөн автомашины хувийн хэрэглээ, хуулиар тогтоосон хязгаараас хэтэрсэн нөхөн олговортой бизнес аяллын зардал гэх мэт) олгосон бүх төрлийн орлого хамаарна.
- 2. Өмчийн нөхөн олговор.** Урамшууллын нэг хэсэг болгон хувьцаа эсвэл өмчийн хэрэгсэл авсан бол түүнд шууд татвар төлөх шаардлагагүй буюу хувьцаагаа дараа нь зарах үед л татвар тооцно.
- 3. Бизнесийн орлого.** Хувиараа бизнес эрхлэгчийн татвар ногдох орлогыг корпорацынхтай ижил аргаар тодорхойлно.
- 4. Хөрөнгийн өсөлтөөс олсон ашиг.** Хөрөнгийн өсөлтөд 10 хувийн орлогын албан татвар ногдуулдаг. Гэхдээ Засгийн газрын бонд, Засгийн газрын дэмжлэгтэй байгууллагын гаргасан бонд (Agency Bond) нь татвараас чөлөөлөгддөг.
- 5. Ногдол ашгийн орлого.** Ногдол ашгийн орлогод 10 хувийн татвар ногдуулдаг.
- 6. Хүүгийн орлого.** Гадаадын банкнаас авсан хүүгийн орлогод хүүгийн түвшнээс үл хамааран татвар ногдуулдаг бол хяналтын эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулдаг дотоодын банкнуудаас олгосон хүүгийн орлогод татвар ногдуулдаггүй байна.
- 7. Түрээсийн орлого.** Татвар төлөгч эд хөрөнгийг түрээслэх, түрээслэхтэй холбоотой татвар ногдох орлогыг тооцохдоо уг эд хөрөнгийг түрээслэхтэй холбоотой засвар үйлчилгээ, засвар үйлчилгээний зардал, нөхөн төлбөрийг хасаж болно.

Сингапур Улсын туршлага - Сингапур Улс нь татвар ногдох эх үүсвэрээ үндсэн 4 бүлэгт хувааж үзсэн. Үүнд хөдөлмөр эрхлэлтийн орлого, худалдаа, бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн орлого, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалт болон бусад орлого, бусад эх үүсвэрээс олсон орлого багтах ба эдгээр нь илүү дэлгэрэнгүй орлогуудаар тодорхойлогдоно. Жишээлбэл, худалдаа, бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид хэмээх ерөнхий бүлэгт 14 өөр төрлийн орлогыг тодорхойлж авч үзсэн ба шашин, түүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлж буй иргэдийг энэхүү бүлэгт багтаан үзэж байна. Тэдгээрийн шашинд итгэгчдээс болон бусад үйлчилгээ үзүүлэн авсан мөнгө, үнэ бүхий зүйлсээс татвар ногдуулах ба мөн итгэл, үнэмшлийнхээ дагуу өгсөн бэлгээс ч татвар ногдуулдаг байна.

Сингапур Улсын татвар ногдох эх үүсвэрүүд болон ногдохгүй эх үүсвэрүүд тодорхой ба хэрхэн ногдуулах, ямар байдлаар төсөвт тусгах нь дэлгэрэнгүй, эх үүсвэрүүдийн давхцал эсвэл ойлголтын зөрүү үүсэхээргүй байгаа нь татвар төлөгчдөд ойлгомжтой хялбар байна. Мөн татвар хэрхэн ногдуулах, хураах, төсөвт шилжүүлэх талаар заавар, жишиг материал тухайн улсын татварын байгууллагын цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээнд өргөн тархсан байгаа нь татвар хураалтад эерэг нөлөө үзүүлдэг байж болох юм.³¹

Ирланд Улсын туршлага - Ирланд Улс нь татвар ногдох эх үүсвэрээ үндсэн 6 бүлэгт хувааж үзсэн. Үүнд хөдөлмөр эрхлэлтийн орлого, бизнесийн орлого, хүүгийн орлого, түрээсийн хөрөнгө, Ирланд дах хөрөнгийн өсөлт, ногдол ашгийн орлого, хүүгийн орлого байх ба эдгээр нь илүү дэлгэрэнгүй орлогуудаар тодорхойлогдоно. Жишээлбэл, хөдөлмөр эрхлэлтийн үр дүнд бий болсон бүх төрлийн орлогод орлогын албан татвар ногдуулж байна. Үүнд: цалин, гүйцэтгэлийн урамшуулал, илүү цагийн төлбөр, мөнгөн бус урамшуулал (компанийн байр, машиныг хувийн хэрэглээндээ ашиглах, хөнгөлөлттэй зээл г.мэт), хувьцааны опцион, тэтгэвэр эсвэл даатгалын төлбөр, ажлаас халагдсаны тэтгэмж, өвчтэй байсны төлбөр, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, олон нийтийн амралтын өдөр ажилласан нэмэгдэл, гадаадын иргэний Ирландад ажиллаж олсон орлого, Ирландын оршин суугч гадаадад ажиллаж олсон орлого гээд нийт 11 төрлийн хөдөлмөр эрхлэлтэй холбоотой орлого багтаж байна.

Ирланд Улсын татвар ногдох болон ногдохгүй эх үүсвэрүүд нь тодорхой ба тэдгээрээс татвар тооцох, хураах, иргэд тайлагнах зэргийг илүү хялбаршуулсан байдаг нь ХХОАТ илүү үр ашигтай байх суурь болж өгдөг байна.

6.1.4 ХХОАТ тооцоолох, тайлагнах, төлөх үйл явцыг хялбар, ойлгомжтой болгох.

Казахстан Улсын туршлага – Казахстан улс ХХОАТ-ыг тооцох, тайлагнах, төлөх үйл явцыг хялбарчлах олон арга хэмжээ авч хэрэгжүүлснээс татвар төлөгчтэй харилцах, хуулийг дагаж мөрдөх байдлыг хөнгөвчлөх, тайлагналыг цахимжуулах, иргэдийн дундах татварын боловсролд анхаарах зэргийг хослуулснаар хүртээмжтэй, ил тод, ойлгомжтой татварын тогтолцоог бий болгохыг хичээж ирсэн.

³¹ <https://www.iras.gov.sg/home>

Сингапур Улсын туршлага - Тус улсын хувьд ХХОАТ-ын тайлангаа тооцоолон бэлтгэх жишиг бэлтгэсэн байдаг ба мөн тухайн улсын татварын байгууллагын цахим хуудсаар дамжуулан өөрийн орлого, түүнээс хасагдах зардлаа тооцон ХХОАТ-ын тайлангаа урьдчилан тооцоолох боломжийг бүрдүүлж өгсөн байдаг. Мөн хэрхэн бэлтгэх зааврыг дэлгэрэнгүй, олон төрлийн жишээгээр баяжуулан цахим хуудсандаа байршуулж, иргэдээ тогтмол мэдээллээр хангаж байдаг байна.

Иргэдийн татварын боловсрол, татвар тайлагнахын ач тусыг тогтмол цахим болон бусад хэлбэрээр сурталчилж, эргээд улсын зүгээс тэдгээрийн татварын тайлангаа илгээх систем, тооцох аргачлалыг хялбарчилж өгсөн байдаг нь тухайн улсын татварын тогтолцоо үр ашигтай байгаагийн шалтгаан болж байна.

Ирланд Улсын туршлага - Хувиараа хөдөлмөр эрхлэгчид орлогын албан татвараа өөрсдөө жил бүр тооцож, төлөх үүрэгтэй байдаг ба татвар ногдуулах орлогод бизнесийн ашиг болон бусад орлого хамаардаг байна. Хэрэв төлөх ёстой аливаа татвараа хожимдуулсан бол төлөх хугацаанаас эхлээд төлбөрийг хүлээн авах хүртэлх хугацаанд хүү тооцож төлдөг. Мөн татварын мэдээллийн бааз өргөн бөгөөд татвар тайлагнах систем нь татвар ногдох эх үүсвэр бүрээр тусад нь тооцож болохоор энгийн хялбар байдлаар шийдсэн байдаг байна.

6.2 ХХОАТ-ын бодлогын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарууд

Дээрх улсууд нь өөрийн гэсэн татварын орчин, онцлогтой ба тэдгээрт хамгийн сайн тохирсон татварын бодлогыг хэрэгжүүлж байна. Тухайн улсуудын бодлого нь ижил төстэй болон ялгаатай олон төрөл буй ба тэдгээрээс Монгол Улсын онцлогт тохирох, олон улсад сайн шийдэл байж болохоор хүлээн зөвшөөрөгдсөн туршлагыг судлахыг зорив.

Дээрх улсуудын туршлага, өмнө судлагдсан мэдээллүүд, олон улсын болон Монгол Улсын судлаачдын судалгааны ажил дээр үндэслэн энэхүү сэдвийн хүрээнд тодорхойлсон асуудалдаа дараах шийдлүүдийг санал болгож байна.

Асуудал 1. Албан татварын шударга байх зарчим зөрчигдсөн.

ХХОАТ-ыг улсын төсөвт төвлөрүүлэх болон холбоотой хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад тулгарч буй асуудлуудыг ангилан дараах байдлаар тодорхойлсон ба албан татварын шударга байх зарчим зөрчигдсөн асуудлыг дараах байдлаар шийдэж болно гэж үзэв. Үүнд:

- ✓ Татвар ногдуулах боломжтой иргэдийн бодит мэдээлэл цуглуулах, тэдгээрийг ангилан, боловсруулан ашиглаж үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;
- ✓ Түрээсийн орлогоос татвар тооцох арга зүйг сайжруулах, түрээсийн орлогын татварт тодорхой хөнгөлөлтүүдийг олгох боломжийг судлах;
- ✓ Малын ашиг шимээр хийсэн бүтээгдэхүүнийг борлуулсан орлого, шашны үйл ажиллагаанаас олсон орлого, хувиараа такси, тээвэрт явж олсон орлого, бичил

болон жижиг үйл ажиллагаа эрхлэгчдийн орлого зэрэг татвар ногдуулахад төвөгтэй, нарийн зохицуулалтгүй орлогуудад татвар ногдуулах болон хөнгөлөх боломжийг нарийвчлан судлах, нөхцөл байдлыг сайжруулах арга замыг тодорхойлох;

- ✓ Татвар төлөгч иргэдэд чиглэсэн татварын ашиг тусыг таниулсан сургалт, сурталчилгааг илүү эрчимжүүлэх, тогтмол явуулах.

Асуудал 2. ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт оновчтой биш.

ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт оновчтой биш байна гэсэн асуудлыг дараах байдлаар шийдэж болно гэж үзэв. Үүнд:

- ✓ Хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын зорилтот сегментийг тодорхойлох чиглэлээр бодлогын судалгаа хийх, тэдгээрт нийцэх хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийн боломжийг санал болгох;
- ✓ Хөнгөлөлт, чөлөөлөлтийг оновчтойгоор буюу зорилтот сегмент болон хэрэгжүүлэх бодлогод тохируулан тодорхойлох;
- ✓ Бүх төрлийн татварын хөнгөлөлтийг жилд нэг удаа олгодог болох. Цалингийн орлогын татварын хөнгөлөлтийг сард нэг удаа цалингаас тооцсон татвараас шууд суутгах байдлаар хөнгөлөлт үзүүлдэг ба үүнийг хуримтлуулан жилийн эцэст олгох нь татварын боловсролыг нэмэгдүүлэх, үнэ цэнийг илүү мэдрүүлэх ашиг тустай байх боломжтой. Хөнгөлөлт, чөлөөлөлт олгохдоо тухайн хүний санхүү болон нийгмийн нөхцөл байдлыг тусгах. Үүнд тухайн хүний гэр бүлийн байдал, ам бүлийн гишүүдийн тоо, ажил эрхэлж буй өрхийн гишүүний тоо, тэжээлгэгч иргэдийн тоо зэргийг харгалзах;
- ✓ Татвар төлсөн, тайлагнасан иргэдийг урамшуулах, мөн тайлагнаагүй тайлагнах хугацаанаас хоцроосон иргэдэд торгууль ногдуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох;
- ✓ Төрийн албанд, тэр дундаа эрэлт, хэрэгцээ өндөр байгаа мэргэжлүүдээр ажиллаж буй албан хаагчдад ХХОАТ-аас бүрэн чөлөөлөх хүртэлх байдлаар дэмжих (багш, эмч).

Асуудал 3. ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн ангилал хэт ерөнхий, тодорхой бус.

ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн ангилал хэт ерөнхий, тодорхой бус байна гэсэн асуудлыг дараах байдлаар шийдэж болно гэж үзэв. Үүнд:

- ✓ Үйл ажиллагааны орлогуудад ямар төрлийн үйл ажиллагаанаас олсон орлогыг авч үзэх талаар нарийвчлан тодорхойлох;
- ✓ Татвар ногдох орлогыг хэрхэн тооцох арга зүйг дэлгэрэнгүй тодорхойлох (жишээ нь, түрээсийн орлого);

- ✓ Үйл ажиллагааны орлогын татвар ногдуулах орлого дунд «... загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого» гэж заасан байдаг ба мөн бусад орлогын татвар ногдуулах орлого дунд «урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого» гэж заасан байдаг нь давхацсан ба тэдгээрт ногдуулах татварын хувь хэмжээ ялгаатай байгаа зэрэг нь татвар төлөгчдийг төөрөгдүүлж байж болно. Тиймээс эдгээрийг илүү тодорхой болгох;
- ✓ ҮХХ болон хөдлөх хөрөнгийг борлуулсан тохиолдолд л татвар авах заалтад бэлэглэсэн болон бусад шалтгаанаар шилжүүлсэн тохиолдолд татвар ногдуулах арга зүйг нэмэх;
- ✓ Шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрэх үед зохицуулалтын орчныг судлах, түр журам батлах үүрэг хүлээх түр хороо байгуулах зарчим, арга зам, боломжийг тодорхойлох.

Асуудал 4. ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн хувьд хэрхэн тайлагнах, төлөх, тооцоолох нь хялбар, ойлгомжтой биш.

ХХОАТ ногдох зарим орлогын эх үүсвэрийн хувьд хэрхэн тайлагнах, төлөх, тооцоолох нь хялбар, ойлгомжтой биш байна гэсэн асуудлыг дараах байдлаар шийдэж болно гэж үзэв. Үүнд:

- ✓ Татвар төлөгч иргэдэд чиглэсэн татварын үр ашгийг таниулсан болон ХХОАТ төлөх арга зам, хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх боломжийг ойлгомжтой тайлбарласан сургалт, сурталчилгаа, контентыг илүү эрчимжүүлэн бэлтгэж, тогтмол мэдээлэх;
- ✓ Татварын мэргэшсэн зөвлөхийн талаар таниулах, сурталчлах;
- ✓ Хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлогыг хэрхэн тайлагнах, төлөх, тооцоолохыг тодорхойлох;
- ✓ ХХОАТ тайлан илгээх үйл явц нь суутган төлөгч, тухайлбал, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, хүүгийн болон ногдол ашгийн орлого, хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого болон шууд бус орлогод ногдох албан татварыг тайлагнахад илүү хялбар буюу системээс мэдээллийг шууд татан авах боломжтой байдаг. Гэвч үйл ажиллагаа эрхлэгч, ҮХХ түрээслүүлэгч болон бусад орлогыг тайлагнах үйл явц илүү хүндрэлтэй, иргэдэд ойлгомжгүй байх ба өөрөө тайлагнах татвар төлөгчдөд ebarimt-ийн системийг ашиглан ХХОАТ-ын тайлангаа илгээх боломжийг илүү хялбаршуулах, системийн тогтмол үйл ажиллагааг хангаж ажиллах;
- ✓ ХХОАТ тооцох хялбаршуулсан туршилтын систем, цахим хуудсаа сайжруулах, шинэ хэрэглүүрүүдийг нэмэх.

ДУГНЭЛТ

Хувь хүний орлогын албан татвар нь төсвийн орлогын нэг чухал эх үүсвэр бөгөөд төрийн үйлчилгээ, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бий болгох, мөн орлогын тэгш байдал, ажиллах хүчний оролцоо, эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангаж, нийгмийн боломжит салбарыг дэмжих, хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий албан татварын нэг юм. Монгол Улсын хувьд ХХОАТ-ын тогтолцооны эхлэл нь 1990 оны зах зээлийн эдийн засагт шилжих үед тавигдаж, 1993 оноос хойш хүн амын орлогын албан татвар нэртэйгээр хэрэгжиж эхэлсэн байдаг. Түүнээс хойш, хэд хэдэн удаа тус хуульд шинэчлэлт, өөрчлөлт хийсний үндсэн дээр өнөөгийн ХХОАТ-ын хуулийн зохицуулалт бүрэлдсэн байна.

2021 оны байдлаар татварын орлогын ДНБ-д эзлэх хэмжээ 25 хувьд хүрсэн нь бусад ижил түвшний улсуудтай харьцуулахад Монгол Улсын татварын ачаалал өндөр байгааг илтгэж байна. Энэхүү өндөр ачаалал нь татварын суурийг хангалттай тэлж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд шударга татвар төлөгчдөд ирэх татварын ачааллыг нэмэгдүүлж буй хэрэг юм.

Татварын нийт орлого 2022 оны гүйцэтгэлээр 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 37.8 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс ХХОАТ 9 хувийг бүрдүүлж байна. Хэдийгээр ХХОАТ-ын тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгө ба хөрөнгө борлуулсны болон бусад бүх орлогоос татвар төлөхөөр заасан боловч ХХОАТ-ын орлогын 70-75 хувийг нь зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого, харин үйл ажиллагааны орлогоос төлсөн татварын дүн 4-6 хувийг тус тус бүрдүүлж байна.

Олон улсын түвшинд ХХОАТ-т хамрагдах орлогын эх үүсвэрийн нийтлэг хандлага нь хөдөлмөр эрхлэлтийн орлого, бизнесийн орлого, хөрөнгө шилжүүлсний орлого, ногдол ашгийн орлого, түрээсийн орлого, хүүгийн орлого гэсэн орлогын төрлүүдийг орлогын эх үүсвэрт тооцож байна. Монгол Улстай харьцуулахад улс орон бүр татварын тогтолцоондоо өөрийн гэсэн онцлогтой, тэргүүлэх чиглэлтэй байна. Тухайлбал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын зорилтыг тусгасан, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн тодорхой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн тусгай заалтууд мөн ажиглагдаж байна.

2023 оны байдлаар Монгол Улсад ХХОАТ-ын 21 төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь бусад дундаж орлоготой улсуудтай харьцуулахад их байна. Мөн хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогоор дамжуулан хүн амын нийгмийн асуудлыг зохицуулахаас гадна татвараа үнэнч шударгаар өөрөө тодорхойлон төлөх байдлыг урамшуулж байх шаардлагатай ч энэ нь манай улсын хувьд хангалтгүй байна.

ХХОАТ-ын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг илүү үр ашигтай байлгахад ХХОАТ зөв, оновчтой зарчмаар ажиллаж байх ёстой. Иймд тус судалгаагаар Монгол Улсад хэрэгжиж буй ХХОАТ-ын тухай хууль, түүний хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдлыг Адам

Смитын тодорхойлсон татварын 4 зарчим болон олон улс дахь сайн түршлагыг ашиглан (1) Шударга эрх тэгш буюу төлбөрийн чадварт нийцсэн, (2) Тохиромжтой, (3) Тодорхой, (4) Үр ашигтай байх гэсэн үндсэн 4, тэдгээрт хамаарах дэд 12 шалгуур үзүүлэлт, мөн шалгуур тус бүрийн хэмжих зарчмыг тодорхойлсон болно.

Хамгийн эхний үндсэн шалгуур нь шударга, эрх тэгш буюу төлбөрийн чадварт нийцсэн байх зарчим юм. Тус зарчмын хүрээнд иргэдийн санхүүгийн нөхцөл байдалд тохирсон байдлаар татвар ногдуулах, ногдуулсан албан татварыг татвар төлөгч бүр шударгаар төлөх гэсэн 2 чухал дэд шалгуурыг агуулж байна.

Нэгдүгээр шалгуурт, албан татвар нь иргэдийн санхүүгийн нөхцөл байдалд тохирсон байх ёстой хэдий ч Монгол Улсын хувьд олон улсад хэрэгжиж буй ажилтай ээж, өрх толгойлсон эцэг, эхийн орлого зэрэг хувь хүний нөхцөл байдалд тохирсон татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх тогтолцоо дутмаг байна. Одоогийн байдлаар зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шугамаар ХХОАТ-аас бүрэн чөлөөлөх зохицуулалт л хэрэгжиж байгаа тул бусад төрлийн эрх агуулагчдын хувьд ХХОАТ нь санхүүгийн нөхцөл байдалд нь дарамт учруулж байж болзошгүй юм. Иймд ХХОАТ-ын тухай хууль тогтоомжид энэ төрлийн бодлого, зохицуулалтыг нэвтрүүлэх нь бас нэгэн оновчтой шийдэл байж болох юм.

Хоёрдугаарт, татвар төлөгч бүр шударгаар албан татвар төлөх ёстой хэдий ч Монгол Улсын хувьд цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын эх үүсвэр, дотоодын зах зээлд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого болон шүүд бус орлого зэрэг татварыг суутган төлөх тогтолцоогоор хэрэгжүүлж буй орлогын эх үүсвэрт ногдуулж буй татварын гүйцэтгэл өндөр, хэрэгжилт сайн байна. Харин үйл ажиллагааны орлого, хөрөнгө ашиглуулсан, түрээслүүлсний орлого, гадаад улс оронд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого болон бусад орлогод ногдох татварыг татвар төлөгч өөрөө тайлагнах, төлөх зарчмаар хэрэгжиж байгаа тул тэдгээрт тавих хяналт, зохицуулалт сул байна. Иймд ХХОАТ-ын ачаалал албан татвар шударгаар төлж буй хэсэгт илүү их төвлөрч байна. Мөн зарим орлогод ногдох татварын хэрэгжилт сул байгаа нь татвар төлөгчдийн татвар төлөх, тайлагнах мэдлэг, мэдээлэл дутмаг, мөн татварт хандах сөрөг хандлага нэмэгдэж буй зэргээс шалтгаалж байна. Үүнээс үүдэн Монгол Улс дахь татвар төлөгчид өөрт ногдох албан татварыг шударгаар төлөх зарчим бүрэн хэрэгжихгүй байгааг харж болно. Иймд Засгийн газраас татвар төлөгчдийн татвар төлөх, тайлагнах мэдлэг мэдээллийг сайжруулах, албан татвар өөрөө тайлагнах үеийн хяналтын тогтолцоог нэмэгдүүлэх болон хамгийн чухал зүйл нь татварт хандах сөрөг хандлагыг бууруулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх асуудлыг чухалчлан авч үзэн ажиллах шаардлагатай байна.

Хоёр дахь үндсэн шалгуур болох “тохиромжтой байх” зарчмын хувьд, олон улсын жишиг зохицуулалтаас харахад, иргэдийн санхүүгийн нөхцөл байдалд тохирсон албан татварыг ногдуулахын тулд Монгол Улсын татвар төлөгчдийн гол хувьсагч үзүүлэлтүүд болох өрхийн гишүүдийн тоо, тэдгээрээс ажил эрхэлж буй гишүүдийн тоо, тэжээлгэгч гишүүдийн тоо болон хөдөлмөрийн бүтээмж, мэдлэг үр чадвар зэрэг хувьсагчдыг

тусгаж өгч, тэдгээрт тохирсон албан татвар ногдуулах нь “ХХОАТ тохиромжтой байх” зарчмыг хангахад чухал алхам болох боломжтой. Мөн оршин суугч бус татвар төлөгчдөд ногдуулах хувь хэмжээг тухайн татвар төлөгчийн ажиллаж буй салбар, чиглэлийн Монгол Улсын эдийн засаг, байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж, ихэсгэх болон багасгах тохиргоог бий болгох нь Монгол Улсын нийгэм эдийн засагт эерэг нөлөөллийг үзүүлнэ.

Гурав дахь үндсэн шалгуураар Монгол Улсын ХХОАТ-ын тухай хуульд заасан албан татвар ногдуулах хувь хүний орлогын эх үүсвэр, тэдгээрт ногдуулах албан татварын хувь хэмжээ болон татварыг төлөх хэлбэр болон хугацаа, түүнийг тайлагнах талаарх мэдээлэл нь татвар төлөгчдөд ойлгох болон хэрэгжүүлэхэд хэр хялбар болохыг тодорхойлсон. Хэдий ХХОАТ-ын тухай хууль нь товч, тодорхой, ирээдүйд шинээр бий болох орлогын эх үүсвэрийг хамруулах боломжтой өргөн хүрээг хамарсан нь сайн талтай боловч татвар төлөгчид татвар ногдуулах орлогын эх үүсвэрээ тодорхойлоход бэрх, зарим утга агуулга давхардаж ойлгогдох магадлалтай байна. Тодруулбал, үйл ажиллагааны орлогыг тодорхойлсон тодорхойлолт нь хэт өргөн цар хүрээг хамарч байгаа хэдий ч Монгол Улсын эдийн засагт нөлөө бүхий үйл ажиллагааны салбарт ажиллаж буй бөөний, жижиглэн худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааны орлого, малчдын мал, малын түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүнээс олсон орлого болон шашин шүтлэгтэй холбоотойгоор лам, бөөгийн засал үйлчилгээний орлого зэргийг албан татварт хамруулж буй байдал бага байгаа нь үйл ажиллагааны орлого хэт ерөнхий, яг ямар төрлийн орлого тус ангилалд хамаарахыг тодорхойлоход бэрх байгаагаас шалтгаалж байна. Иймд тэдгээр тодорхой бус болон тусгагдаагүй зүйлсийг ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шинэчлэн тогтоох нь ХХОАТ-ыг улам төгөлдөржүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж судалгааны багийн зүгээс үзэж байна.

ХХОАТ-ын хамгийн сүүлийн шалгуур нь үр ашигтай байх зарчим юм. Уг зарчмын дагуу Монгол Улсын ХХОАТ ногдуулах орлогын эх үүсвэрийн санхүү, төсвийн үүрэг буюу ХХОАТ-ын төлөвлөгөөний биелэлт болон зохицуулалтын үүргийн хэрэгжилт, нөлөөллийг тус бүрчлэн тодорхойллоо. Орлогын 6 ангилал бүхий эх үүсвэрүүдээс цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох албан татвар ХХОАТ-ын 70-75 хувийг бүрдүүлж байгаа тул бусад орлогын эх үүсвэрийн санхүү, төсвийн үүргийн биелэлтийг бүрэн гэж дүгнэхэд учир дутагдалтай юм. Харин зохицуулалтын үүргийн хувьд албан татварт нийгмийн хамгаалал, боловсролыг дэмжих болон байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг үзүүлж байна. Гэвч тэдгээртэй холбоотой нээлттэй мэдээлэл тус зохицуулалтын үүргийг хэмжихэд хангалттай биш гэж үзэж байна.

Дээрх үндсэн 4 шалгуурын хүрээнд ХХОАТ-ын тухай хууль, түүний хэрэгжилт, түүнд тулгарч буй асуудал бэрхшээлийг тодорхойлон, тэдгээрийг засаж сайжруулах хамгийн боломжит алхам нь ХХОАТ-ын тухай хуульд дараах өөрчлөлт, шинэчлэлтийг оруулах явдал юм. Үүнд, ХХОАТ ногдуулах орлогын эх үүсвэрүүдийн ангилалд багтах орлогыг нарийвчлан тодорхойлох, татвар төлөгчдийн санхүүгийн нөхцөл байдалд тохирсон нөхцөлт хөнгөлөлтийг нэвтрүүлэх, мөн албан татварыг татвар төлөгч өөрөө төлөх, тайлагнах тогтолцоон дахь хяналтыг сайжруулах нь чухал байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны хүрээнд Монгол Улсын ХХОАТ-т ногдох эх үүсвэрүүдийг олон улсын туршлагатай харьцуулан судалж татвар ногдох орлогын ангилал, хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг оновчтой тодорхойлох чиглэлээр манай орны эдийн засаг, хууль, соёл болон хүн ам зүйн хүчин зүйлсэд нийцсэн, ХХОАТ-ын энгийн ойлгомжтой байдлыг сайжруулах, татвар төлөгчдийн татварт хандах эерэг хандлагыг нэмэгдүүлж, татварыг шударгаар төлөх замаар ХХОАТ-ын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгааны багын зүгээс дараах хувилбаруудыг санал болгож байна. Үүнд:

Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, тогтоомжид дараах шинэчлэлт, өөрчлөлтийг хийх шаардлагатай:

- ✓ ХХОАТ-ын тухай хуульд албан татвар ногдуулж буй орлогын эх үүсвэрийн ангилал тус бүрд хамаарах орлогыг нарийвчлан тодорхойлж, шаардлагатай зарим эх үүсвэрийг нэмж, олон нийтэд мэдээлэх. Тухайлбал:
 - ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.2-т мал, малын түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын орлого, цахим контент, зар сурталчилгаанаас олсон орлого, онлайн худалдааны орлого, шашны үйл ажиллагааны орлогыг дэлгэрэнгүй тодорхойлж тусгах;
 - ХХОАТ-ын хуулийн 8.1.4-т дараах орлогын эх үүсвэрийг тусгах. Үүнд: шашны үйл ажиллагаатай холбоотой үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, үйлчилгээ болон түүнтэй адилтгах орлогыг тусгах;
 - Үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх хөрөнгийг борлуулсан болон өв залгамжлалаас бусад тохиолдол дахь шилжүүлсний орлогод татвар ногдуулах.
- ✓ ХХОАТ-ын тухай хуульд татвар ногдуулах эх үүсвэрүүдийн давхардсан агуулгыг залруулах.
 - Үйл ажиллагааны орлогын татвар ногдуулах орлого дунд «... загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого» гэж заасан байдаг ба мөн бусад орлогын татвар ногдуулах орлого дунд «урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого» гэж заасан байдаг нь давхацсан ба тэдгээрт ногдуулах татварын хувь хэмжээ ялгаатай байгааг илүү тодорхой болгох.
- ✓ Зах зээлд шинээр бий болж буй ХХОАТ ногдуулах орлогын эх үүсвэрийг цаг тухайд нь хамруулах боломжийг бүрдүүлэх буюу шинэ төрлийн бүтээгдэхүүн,

үйлчилгээ нэвтрэх үед зохицуулалтын орчныг судлах, түр журам батлах үүрэг хүлээх түр хороо байгуулах арга зам, боломжийг тодорхойлох;

- ✓ Хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлогод татвар ногдуулах, тайлагнах зохицуулалтыг сайжруулж, тодорхойлох. Тухайлбал:
 - ХХОАТ-ын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 19.1-д хөрөнгө түрээслүүлснээс олсон нийт орлогоос тухайн хөрөнгийг түрээслүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хассан зөрүүгээс татвар ногдуулна гэсэн заалтад холбогдон гарах зардлын мэдээллийг дэлгэрэнгүй тодорхойлох;
 - Хөрөнгө ашиглуулсан, түрээслүүлсний орлогод албан татвар ногдуулан төлөх, тайлагнах үйл явцад хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;
 - Хөрөнгө ашиглуулсан, түрээслүүлсний орлогын албан татварт тодорхой хөнгөлөлтүүдийг олгох боломжийг судлах.
- ✓ Олон улсын түршлагад тулгуурлан иргэдийн нийгмийн болон санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж ангилан, тэдгээрт тохирсон хөнгөлөлт, чөлөөлөлтийг тодорхойлох.
 - Оршин суугч бус татвар төлөгчийн ажиллаж буй салбар нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хэр эерэг нөлөөллийг бий болгож буйгаас шалтгаалан ногдох хувь хэмжээнд өөрчлөлт оруулах.

Татвар төлөгчдийг бүрэн хамруулж, ХХОАТ-ын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд:

- ✓ Татвар төлөгч иргэдэд чиглэсэн татварын үр ашгийг таниулсан болон ХХОАТ төлөх арга зам, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийг ойлгомжтой тайлбарласан сургалт, сурталчилгаа, контент бэлтгэн, тогтмол мэдээлэх;
- ✓ Татварт хандах эерэг хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр тэдгээр нөлөөлж буй хүчин зүйлсийг арилгах арга хэмжээг авах;
- ✓ ХХОАТ-ын хяналтын системийг сайжруулах;
- ✓ Татварын мэргэшсэн зөвлөхийн талаар таниулах буюу тэдгээрийн нийгэмд авчрах үр өгөөж, үндсэн чиглэлийн талаар дэлгэрэнгүй сурталчлах;
- ✓ Татварын тайлангаа өөрөө тайлагнах татвар төлөгчдөд зориулан ebarimt-ийн системийг ашиглан ХХОАТ-ын тайлан илгээх үйл явцыг илүү хялбаршуулах, системийн тогтмол үйл ажиллагааг хангаж ажиллах;
- ✓ Татвар төлсөн, тайлагнасан иргэдийг урамшуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох.

Хавсралт 1. Сингапур Улсын татвар ногдох орлогын эх үүсвэрүүд

Хувь хүний орлогын татварын бүлэг	Татвар ногдох эх үүсвэрүүд	Эх үүсвэрүүдийн дэлгэрэнгүй задаргаа
Хөдөлмөр эрхлэлтийн орлого	Цалин түүнтэй адилтгах орлогод ногдох татвар	Цалингийн орлогод ногдох татвар
		Цалингийн урамшууллын орлогод ногдох татвар
		Захирлын цалингийн орлогод ногдох татвар
		Үйл ажиллагааны орлогод ногдох татвар
		Бусад хөдөлмөр эрхлэлтэд ногдох татвар
	Хувьцаа, ногдол ашгийн орлогод ногдох татвар	ESOP ESOW ³²
	Гадаад улсаас хүлээн авсан орлого	Сингапур дахь түншлэлээрээ дамжуулан авснаас бусад үед татвар ногдохгүй
Тэтгэвэрт ногдох орлого	Тэтгэврийн санд хуримтлуулж буй хуримтлалд ногдох татвар	
Тэтгэвэр, тэтгэмж	Тэтгэвэрт гарахаас өмнө батлагдсан тэтгэвэр, тэтгэмжийн сангаас авсан тэтгэмжид ногдох татвар	
Ажлаас халагдсаны тэтгэмж	Payment in lieu of notice ³³ , өргөдөл	
Худалдаа, бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж олсон орлого	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд ногдох орлого	14 төрлийн үйл ажиллагааны орлогыг энэ төрлийн орлогод хамруулаар зааж өгсөн.
	Гадаад улсаас хүлээн авсан орлого	Сингапур дахь түншлэлээрээ дамжуулан авсанаас бусад үед татвар ногдохгүй
	Дижитал токенууд дахь татварын зохицуулалт	Биткойн болон бусад төрлийн койн, токенуудын ашигт ногдох татвар
	Засгийн газрын тэтгэлэг хэлбэрээр хүлээн авсан орлого	Автоматаар татварын тайланд оруулах орлого
Үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс олсон орлого	Түрээслүүлсэн үл хөдлөх хөрөнгийн орлого	Үл хөдлөх хөрөнгийн бүрэн болон хэсэгчилсэн түрээс, түрээсийн барьцаанд болон засвар үйлчилгээнд ногдох татвар
	Ногдол ашгийн орлого	Хоршоодын ногдол ашиг, Сингапур дахь түншлэлээр дамжуулан хувь хүмүүсийн олж авсан ногдол ашигт ногдох татвар
	Хүүгийн орлого	Зөвшөөрөлгүй компани, банкнаас авах хүүгийн орлого, ломбард, хувь хүн, компаниас зээлсэн зээл, хадгаламжийн хүүд ногдох татвар
	Хөрөнгө борлуулсаны орлого	Ашиг олох зорилгоор борлуулсан хөрөнгийн дүнд ногдох татвар
Бусад эх үүсвэрийн орлого	Анниути	
	Төлбөр (тэтгэлэг, засвар үйлчилгээний төлбөр)	
	Үл хөдлөх хөрөнгө/Итгэлцлийн орлого	
	Үндэсний хэмжээний шинжлэх ухаан, анагаах ухаан, боловсролын шагнал	
	Шагнал, урамшуулал	
	Ашиглах эрхийн орлого	

Эх сурвалж: Сингапур Улсын Татварын алба

³² ESOW /Employee Share Ownership/ - Ажилчдад хувь эзэмшүүлэх хөтөлбөр

³³ Payment in lieu of notice - Ажлаас халагдсаны тэтгэмж

Хавсралт 2. Сингапур Улсын ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт

Хөнгөлөлт, чөлөөлөлтийн төрлүүд	Нарийвчилсан зохицуулалт, шаардлага	Нөхцөл	Хөнгөлөлтийн хэмжээ	
			Энгийн иргэн	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
Орлогын хөнгөлөлт	Хөдөлмөр эрхлэлтийн орлого	55-аас доош	\$1,000	\$4,000
	Тэтгэврийн орлого	55-59	\$6,000	\$10,000
	Үйл ажиллагааны орлого	60-аас дээш	\$8,000	\$12,000
Гэрлэлтийн хөнгөлөлт	Гэрлэсэн хүндээ тусалж байгаа бол хэрвээ тусламж авч байгаа хүн энгийн бол жилийн орлого нь \$4000-аас хэтрэхгүй байх	Гэрлэсэн хүндээ	\$2,000	\$5,500
	Салсан эхнэртээ тусалж байгаа бол хууль ёсоор салсан байх	Салсан бол	\$2,000	\$3,500
Төрийн албаны ажилтны хөнгөлөлт	Энэ тусламжийг авах эрхтэй эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан байна	Өөрөө төрийн албан хаагч	\$3,000	\$5,000
	Тухайн улсын иргэн байх	Албан хаагчийн эцэг, эх	\$1,500	\$3,500
	Албан ёсны хамааралтай байх	Албан хаагчийн эхнэр	\$750	\$700
Эцэг, эхийн хөнгөлөлт	Төрсөн эсвэл хадам эцэг, эхээ асардаг байх	Хамт амьдардаг	\$9,000	\$14,000
	Тэжээлгэгч нь 55-аас дээш настай эсвэл ямарваа нэгэн хөгжлийн бэрхшээлтэй байх	Хамт амьдардаггүй	\$5,500	\$10,000
Өвөө, эмээгийн хөнгөлөлт	Татвар төлөгч нь өмнөх жилдээ гэрлэлт нь цуцлагдсан байх эсвэл бэлэвсэрсэн байх		\$ 3,000	
	Хүүхэд нь Сингапур Улсын иргэн байх ба 12-оос доош настай байх			
Ажилтай ээжийн хөнгөлөлт	Тухайн улсын иргэн байх	Эхний хүүхэд	15%	
	Ээж нь заавал ажилладаг байх	2 дахь хүүхэд	20%	
	Өмнөх жилдээ гэрлэлт нь цуцлагдсан байх эсвэл бэлэвсэрсэн байх	3 дахь хүүхэд	25%	
	Өмнөх жилдээ үйл ажиллагааны, хөдөлмөр эрхлэлтийн, тэтгэврийн орлогын аль нэгийг олсон байх	4 дэх хүүхэд	25%	
Хүүхдийн хөнгөлөлт	Насанд хүрээгүй, хууль ёсны хүүхэдтэй байх		\$4,000	\$7,500
Хөгжлийн бэрхшээлтэй ах эгчийн хөнгөлөлт	Хууль ёсны дагуу төрсөн ах эгчээ асардаг байх, асруулагч нь өмнө жил Сингапур Улсад амьдарсан байх		\$5,500	
Амьдралын даатгалын хөнгөлөлт	Даатгалын компани Сингапур Улсад салбартай байх		Даатгалын шимтгэлийн дүн	
	Татвар төлөгч нь даатгалыг эзэмшиж байх		Даатгуулсан дүнгийн 7 хүртэлх хувь	
			\$5,000	
Сургалтын төлбөрийн хөнгөлөлт	Сургалт, семинар эсвэл бага хуралд хамрагдсан байх.		\$5,500	
	Ямар ч дүнтэй холбоотой хасалт хийхийг зөвшөөрөхгүй		Төлсөн сургалтын төлбөр	

Эх сурвалж: Сингапур Улсын Татварын алба

Хавсралт 3. Ирланд Улсын ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт

№	Хувийн нөхцөл байдал	Хөнгөлөлт
1	Ганц бие хүн	€1,775
2	Гэрлэсэн эсвэл хууль ёсны хамтран амьдрагчтай	€3,550
3	Бэлэвсэн эсвэл хууль ёсны хамтран амьдрагчаа алдсан, хамааралтай хүүхэдтэй	€1,775
4	Бэлэвсэн эсвэл хууль ёсны хамтран амьдрагчаа алдсан, хамааралтай хүүхэдгүй	€2,315
5	Бэлэвсэн эсвэл хууль ёсны хамтран амьдрагчаа алдсан – Тухайн жил нас барсан	€3,550
6	Бэлэвсэн эцэг эх, нас барсны дараах эхний жил	€3,600
7	Бэлэвсэн эцэг эх (эхнэр нөхөр, хууль ёсны хамтран амьдрагчийн нас барсны дараах хоёр дахь жил)	€3,150
8	Бэлэвсэн эцэг эх (эхнэр нөхөр, хууль ёсны хамтран амьдрагчийн нас барсны дараах гурав дахь жил)	€2,700
9	Бэлэвсэн эцэг эх (эхнэр нөхөр, хууль ёсны хамтран амьдрагчийн нас барсны дараах дөрөв дахь жил)	€2,250
10	Бэлэвсэн эцэг эх (эхнэр нөхөр, хууль ёсны хамтран амьдрагчийн нас барсны дараах тав дахь жил)	€1,800
11	Ганц бие хүний хүүхэд асрагчийн кредит	€1,650
12	Ганц бие эсвэл бэлэвсэн эсвэл хууль ёсны хамтран амьдрагчаа алдсан, 65 болон түүнээс дээш насны татварын кредит	€245
13	Гэрлэсэн эсвэл хууль ёсны хамтран амьдрагчтай, 65 болон түүнээс дээш насны татварын кредит	€490
14	Гэрлэсэн эсвэл хууль ёсны хамтран амьдрагчтай, нэг буюу хэд хэдэн хамааралтай хүнийг асран халамжилж байгаа бол	€1,700 (max)
15	Өөрийгөө асрах чадваргүй нэгнийг асран халамжилж буй ажилтай нэгэн	€75,000 (max)
16	Ажилтны PAYE татварын кредит	€1,775
17	Олсон орлогын татварын кредит	€1,775 (max)
18	Өөрийгөө асрах чадваргүй хүүхдийн татварын кредит	€3,300
19	Хамааралтай хамаатан	€245
20	Хамааралтай хамаатны татварын хязгаар	€16,156
21	Харааны бэрхшээлийн хүний татварын кредит, ганц бие хүн	€1,650
22	Харааны бэрхшээлийн татварын кредит, эхнэр нөхөр эсвэл хууль ёсны хамтрагчийн аль нэг нь харааны бэрхшээлтэй бол	€1,650
23	Харааны бэрхшээлийн татварын кредит, эхнэр нөхөр эсвэл хууль ёсны хамтрагчид хоёул хараагүй бол	€3,300
24	Харааны бэрхшээлтэй, замчлагч нохойтой бол	€825
25	Түрээсийн татварын кредит, ганц бие хүн бол	€500 (max)
26	Түрээсийн татварын кредит, Гэрлэсэн хосууд эсвэл хууль ёсны хамтран амьдрагчид хамтран түрээсэдэг бол	€1,000
27	Татварын хувь хэмжээ: Schedule F	25%
28	Татварын хувь хэмжээ: Онцгой хадгаламжийн аккаунт	33%
29	Татварын хувь хэмжээ: Хадгаламжийн хүү	33%

Эх сурвалж: Ирланд Улсын Татварын алба (2023 он)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 2019 он.
2. World Justice Project, Хууль дээдлэх ёсны индекс, <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/global/2022/Mongolia/>
3. Deloitte, Эстони Улсын татварын онцлох зүйлүүд, 2022 он. <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Tax/dttl-tax-estoniahighlights-2022.pdf>
4. Үндэсний статистикийн хороо, <https://www.1212.mn/mn>
5. Татварын Ерөнхий Газар, <https://mta.gov.mn/home>
6. Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар, <https://burtgel.gov.mn/>
7. Монгол банк, <https://www.mongolbank.mn/mn/>
8. Дэлхийн банк, ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын татварын орлогод “COVID-19”-ийн үзүүлэх нөлөөлөл, 2022 он. <https://www.oecd-ilibrary.org/sites/8a691b03-en/index.html?itemId=/content/publication/8a691b03-en>
9. Татварын ерөнхий газар, Үйл ажиллагааны танилцуулга, 2021 он.
10. Дэлхийн банк, Төсвийн зардлын тойм судалгаа, 2018 он.
11. Санхүүгийн зохицуулах хороо, <http://www.frc.mn/#/home>
12. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, <https://www.schcd.mn/>
13. Татварын ерөнхий газар, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тодотгол, УБ., 2023 он.
14. Дэлхийн банкны нээлттэй мэдээллийн сан, Монгол Улсын Жини индекс, 2018 он.
15. М.Энхсүрэн, ХХОАТ-ын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилт, анхаарах асуудлууд, УБ., 2016 он.
16. Ц.Бямбацогт, Орлогын тэгш бус байдлыг бууруулахад ээлтэй татварын бодлого, УБ., 2020 он.
17. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга, 2019 он.
18. Economic Analytica сэтгүүл, Татвар, татварын бодлого гэж юу вэ?, 2018 он.
19. Татварын ерөнхий газар, Жижиг, бичил сегмент болон хувь хүний татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, УБ., 2022 он.

20. Г.Пагмасүрэн, Хувь хүний орлогын албан татвар ногдуулалтыг сайжруулах нь, УБ., 2018 он.
21. Н.Тунгалаг, Б.Лхагважав, Л.Оюунцэцэг, Татварын үүрэг, хэрэгжилтийн судалгаа, УБ, 2018 он.
22. Irland Revenue Authority of Singapore, <https://www.mof.gov.sg/policies/taxes/personal-income-tax>, <https://www.iras.gov.sg/taxes/individual-income-tax/basics-of-individual-income-tax/tax-residency-and-tax-rates/individual-income-tax-rates>
23. PwC, <https://taxsummaries.pwc.com/singapore/individual/income-determination>
24. Worlddata.info, Монгол Улсын авлигын индекс, 2022. <https://www.worlddata.info/asia/mongolia/corruption.php>
25. Ikon.mn, Татварын ерөнхий газрын ОХБОХ-ийн дарга Д.Тунгалагаас тодрууллаа, “Орон сууц худалдан авсны болон оюутны сургалтын төлбөрийн ХХОАТ-ын буцаан олголтыг шилжүүлж эхэллээ”, УБ., 2022 он.
26. Focus.mn, <https://www.facebook.com/100003802673827/videos/352183713613073/>
27. Адам Смит, Үндэстнүүдийн баялаг, 1776 он.
28. News.mn, Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайханы мэдэгдэл, УБ., 2023 он.
29. Irish Tax Institute, <https://taxinstitute.ie/>
30. <https://www.gov.ie/en/organisation/department-of-finance/>
31. Central Statistics Office, <https://www.cso.ie/en/index.html>
32. <https://www.revenue.ie/en/Home.aspx>
33. <https://ec.europa.eu/eurostat>

ISBN 978-9919-9083-2-4



9 789919 908324